



IRIM ONGOLIA
Independent Research Institute

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ВЭБСАЙТЫН ИЛ ТОД БАЙДАЛ

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

Улаанбаатар

2012 оны 1 сарын 17

“Төрийн байгууллагын вэбсайтын ил тод байдал: мониторингийн тайлан” судалгааг Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын захиалгаар, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр IRIM судалгааны хүрээлэн хийж гүйцэтгэв.

Мониторингийн багийн
зохицуулагч

Сарантуяагийн Мойлтмаа. *IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач, Хуульч*

Зөвлөх:

Чүлтэмсүрэнгийн Тамир. *Монгол Улсын Их Сургуулийн Социологи, Нийгмийн ажлын тэнхимийн багш, Социологийн докторант*

Алдарын Долгион. *IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач, Засаглал ба төрийн бодлогын магистр*

Судлаач:

Содномжамцын Бадамханд. *IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач, Дээд боловсролын удирдлагын магистрант*

Баярмаагийн Эрдэнэ. *IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач, Социологийн магистр*

Нямсүрэнгийн Янжинпагма. *IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач, Социологийн магистрант*

Батболдын Түвшинзаяа. *IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач, Социологич*

Агуулга

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	4
ДҮРСИЙН ЖАГСААЛТ.....	5
ЗУРГИЙНЖАГСААЛТ	6
ОРШИЛ.....	7
1.1. Мониторингийн зорилго, зорилт.....	9
1.2. Судлах зүйл: Төрийн байгуулагын вэбсайтуудын ил тод байдал...	9
1.3. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд.....	10
1.4. Мониторингийн мэдээлэл цуглуулах, боловсруулах арга	12
1.5. Мониторингийн хамарсан хүрээ, цаг хугацаа.....	14
БҮЛЭГ 2. МОНИТОРИНГИЙН ГОЛ ҮР ДҮН: ВЭБСАЙТУУДЫН ИЛ ТОД БАЙДАЛ	16
2.1 МЭДЭЭЛЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ БАЙДАЛ	16
2.2 МЭДЭЭЛЛИЙН НАЙДВАРТАЙ БАЙДАЛ.....	22
2.3 МЭДЭЭЛЛИЙН ЦАГ ҮЕИЙН БАЙДАЛ.....	28
2.4 МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ	31
2.5 ВЭБСАЙТУУДЫН ХЭРЭГЛЭХЭД ХЯЛБАР БАЙДАЛ	38
БҮЛЭГ 3. МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ	46
БҮЛЭГ 4. САНАЛ ЗӨВЛӨМЖ	48
ХАВСРАЛТ 1. СУДАЛГААНЫ АНКЕТ	53
ХАВСРАЛТ 2. СУДЛААЧДЫН ГАРЫН АВЛАГА	60
ХАВСРАЛТ3. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ВЭБСАЙТУУДЫН ЭРЭМБЭЛСЭН ЖАГСААЛТ	74
ХАВСРАЛТ 4. ВЭБСАЙТУУДЫГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДАГУУ ЭРЭМБЭЛСЭН НЭГТГЭСЭН ХҮСНЭГТ.....	89
ХАВСРАЛТ 5. ВЭБСАЙТУУДЫГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДАГУУ ТӨРЛӨӨР НЬ ЭРЭМБЭЛСЭН ХҮСНЭГТ	93
ХАВСРАЛТ6. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙГУУЛАГЫН НЭР, ВЭБ ХАЯГ102	

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд	11
Хүснэгт 2 Тухайн шалгуурыг ямар хэмжээнд хангаж байгааг үнэлэх үнэлгээ.....	14
Хүснэгт 3 2010 ба 2011 оны вэб мониторингийн арга зүйн харьцуулалт	15
Хүснэгт 4 Мэдээллийн холбогдолтойбайдлын эхний 3 байр эзэлсэн вэбсайт	21
Хүснэгт 5 Мэдээллийн найдвартай байдлын эхний 3 байрын вэбсайт	26
Хүснэгт 6 Мэдээллийн цаг үеийн байдлын эхний 3 байрын вэбсайт.....	30
Хүснэгт 7 Мэдээллийн хүртээмжтэй байдлаар эхний 3 байр эзэлсэн вэбсайт	35
Хүснэгт 8 Хэрэглэхэд хялбар байдлын шалгуураар эхний 3 байр эзэлсэн вэбсайт.....	43

ДҮРСИЙН ЖАГСААЛТ

Дүрс 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эзлэх хувь	13
Дүрс 2. Байгууллагын ерөнхий мэдээлэл.....	16
Дүрс 3. Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл	17
Дүрс 4. Хүний нөөцийн ил тод байдал.....	18
Дүрс 5. Байгууллагатай холбоотой материал.....	18
Дүрс 6. Байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдал	19
Дүрс 7. Худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал	20
Дүрс 8. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	23
Дүрс 9. Төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал	24
Дүрс 10. Худалдан авах ажиллагааны ил тод байдал	25
Дүрс 11. Вэбсайт дахь мэдээллийн найдвартай байдал	26
Дүрс 12. Хүний нөөцийн тухай мэдээлэл	28
Дүрс 13. Төсөв санхүүгийн мэдээлэл	29
Дүрс 14. Худалдан авах ажиллагааны мэдээлэл	30
Дүрс 15. Асуулт хариултын булан.....	32
Дүрс 16. Хэлэлцүүлгийн булан.....	33
Дүрс 17. Холбоотой байгууллагын холбоос линк	33
Дүрс 18. Тогтмол асуудаг асуултын хариулт	34
Дүрс 19. Хэлний сонголт	34
Дүрс 20.Мэдээллийн хүртээмжтэй байдлын үзүүлэлтүүд	34
Дүрс 21. Сайтын үсгийн фонт тохиромжтой харагдахуйц байна уу?	39
Дүрс 22. Сайтын цэс ойлгомжтой байна уу?	39
Дүрс 23. Сайтанд өнгөний зохицол байна уу?	39
Дүрс 24. Сайтын бүх мэдээлэл нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байна уу?	40
Дүрс 25. Сайтаас мэдээлэл үншиж үзэхэд шаардлагатай программ татаж авах боломж байна уу? 40	40
Дүрс 26. Дурын браузер тухайн сайт руу орох боломж байна уу?	41
Дүрс 27. Сайтанд алдаа гарч байгаа тохиолдод шийдэх арга замыг зааж өгч байна уу?	41
Дүрс 28. Хайлтын цэстэй вэбсайтуудын хувь	41
Дүрс 29. Сайтанд сайтмап байна уу?	42
Дүрс 30. Сайтаас хэвлэх боломж байна уу?	42
Дүрс 31. Сайтанд файлыг хадгалах боломж байна уу?	42
Дүрс 32. Сайтнаас мэдээллийг бусдад илгээх боломж байна уу?.....	43
Дүрс 33. Хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлтүүд.....	43
Дүрс 34. Шалгуур бүрийн дүн	46

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. НХХЯ-ны вэбсайт	20
Зураг 2. Сонгуулийн ерөнхий хорооны вэбсайт.....	21
Зураг 3. Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын вэбсайт.....	26
Зураг 4. Авто тээврийн газрын вэбсайт.....	26
Зураг 5. УИХ-ын вэбсайт	30
Зураг 6.1. БСШУЯ-ны вэбсайт	35
Зураг 6.2. БСШУЯ-ны вэбсайт	36
Зураг 7.Үндэсний аудитын газрын вэбсайт.....	36
Зураг 8. Батлан хамгаалах яамны вэбсайт.....	44
Зураг 9. Багануур дүүргийн шүүхийн вэбсайт.....	44

ОРШИЛ

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн хүрээнд анх дэлхий даяар цахим засаглал нэр томьёонд тулгуурлан мэдээллийн технологийн хөгжил дэвшлийг төрийн удирдлагад нэвтрүүлэх ажлыг эрчимтэйгээр зохион байгуулж улс орон бүрт энэ талаар тусламж, дэмжлэг үзүүлсээр ирсэн билээ. НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн зүгээс 2002 оноос хойш тогтмол энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх мониторинг судалгааг дэлхийн бүх улс орныг хамруулан хийсээр байна.

Монгол Улсын Засгийн Газрын (МУЗГ) мэдээлэл, харилцаа холбоо, технологийн (МХХТ-ийн) салбарт төрөөс баримтлах дунд хугацааны (2005-2012 он) стратеги, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрийг 2004 онд баталсан билээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд “Цахим Засгийн мастер төлөвлөгөө” боловсруулж Монгол улсад цахим засгийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг автоматжуулах, иргэндээ хандсан, нэг цэгийн, үр дүнтэй, хэмнэлттэй төрийн үйлчилгээг хөгжүүлэх зорилго дэвшүүлсэн. Энэ зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилтын нэг нь байгууллага бүр вэбсайт, иргэн бүрийг цахим шуудангийн хаягтай болгох, төрийн үйлчилгээг сүлжээгээр дамжуулан онлайн горимоор хүргэх явдал юм. Одоогийн байдлаар энэ хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын төрийн байгууллагын 90-ээс дээш хувь нь өөрсдийн албан ёсны вэбсайттай болоод байна. Энэ дэвшилтэт тал нь төрийн байгууллагаас иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх боломж бололцоог нээн өгч байгаа юм.

Сайн засаглалын нэгэн гол шинж чанар бол төрийн байгууллага үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод байлгах явдал билээ. МУЗГ-аас 2008 онд 143 дугаар тогтоолоор төрийн удирдлагын ил тод, нээлттэй, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилго бүхий “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг Засгийн газрын 143 дугаар тоот тогтоолоор (цаашид “Тогтоол” гэх) батлан уг шалгуур үзүүлэлтийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга наарт үүрэг болгосон байдаг. Уг тогтоолд төрийн байгууллагын ил тод байдлыг хангахдаа байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөө санхүү болон худалдан авах үйл ажиллагаатай холбоотой тодорхой мэдээллийг байгууллагын албан ёсны вэбсайтанд байршуулсан байхаар заасан юм.

Энэхүү тогтоолын заалтууд хэрхэн хэрэгжиж байгааг үнэлж, дүгнэх зорилгоор 2010 онд IRIM судалгааны хүрээлэн Авилгатай Тэмцэх Газрын (АТГ) захиалга, НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр Засгийн газрын байгууллагын вэбсайтад нээлттэй мэдээллийн мониторинг хийсэн бөгөөд төрийн байгууллагын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор АТГ-тай хамтран судалгааны үр дүнг танилцуулах хэд хэдэн уулзалт зохион байгуулсан. Энэ удаа судалгааны хүрээгээ өргөтгөж Монгол Улсын төрийн 100 байгууллагын албан ёсны вэбсайтад мониторинг хийснээ танилцуулж байна.

2011 оны мониторинг нь дараах хэд хэдэн онцлогтой юм:

1. Мониторингийн судалгаа нь өнгөрсөн оны судалгаатай харьцуулахад арга зүйн хувьд сайжирсан. Судалгааны арга зүйг олон улсын стандартад ойртуулсан бөгөөд төрийн байгууллагын вэбсайтыг эрэмбэлэх үнэлгээний системийг тодорхой болгосон.
2. Уг судалгаа нь өмнөх онд судалгаанд хамрагдсан вэбсайтын тоог 25 хувиар нэмэгдүүлж Зөвхөн Засгийн газрын байгууллагууд биш Шүүх эрх мэдлийн болон УИХ-ын харьяа байгууллагуудыг хамруулсан.
3. 2010 онд Засгийн газрын 143 дугаар тогтоолд заасан мэдээллийн ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүд нь зөвхөн Засгийн газрын харьяа байгууллагуудад хамааралтай байсан. Харин 2011 онд эдгээр шалгуур үзүүлэлт “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн Хоёрдугаар бүлэгт үндсэн заалт болж орсон тул уг шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг илүү өргөн хүрээнд үнэлэх боломжтой болсон юм. Уг хууль нь:
 - Улсын Их Хурлын Тамгын газар;
 - Ерөнхийлөгчийн Тамгын газар;
 - Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;
 - Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба;
 - Төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага;
 - Бүх шатны шүүх, прокурорын байгууллага;
 - Улсын Их Хурлаас байгуулдаг /Засгийн газраас бусад/ байгууллага;
 - Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажлын алба, орон нутгийн өмчтөг болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
 - Төрийн өмчтөг болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
 - Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллаг-д тус тус хамаарна (Монгол Улсын хууль 2011, 3-р зүйл).

БҮЛЭГ 1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ

1.1. Мониторингийн зорилго, зорилт

Төрийн байгуулагын вэбсайтад мониторинг хийж “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг үнэлэх, цаашдын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар Санал зөвлөмж боловсруулахад оршино.

Энэ хүрээнд доорх зорилтуудыг тавьсан болно:

- Өнгөрсөн оны мониторингийн арга зүйг сайжруулах, ингэхдээ харьцуулагдахуйц байдлыг хадгалах;
- Төрийн байгуулагын вэбсайтуудын орчинд мэдээллийн ил тод байдлыг үнэлэх;
- Мониторингийн үр дүнг өнгөрсөн оны үр дүнтэй харьцуулан шинжлэх;
- Мониторингид хамрагдсан төрийн байгуулагынвэбсайтыг ил тод байдлын үзүүлэлтээр нь эрэмбэлж жагсаалт гаргах;
- Вэбсайтанд тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн санал зөвлөмж боловсруулах.

1.2. Судлах зүйл: Төрийн байгуулагын вэбсайтуудын ил тод байдал

Төрийн байгууллын “ил тод” болон “нээлттэй” гэдэг нь ялгаатай ойлголтууд бөгөөд уг мониторинг эхний ойлголтод суурилна. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын тодорхойлсноорил тод байдал бол сайн засаглалын тулгын гурван чулуу болох хариуцан тайлagnah байдал (accountability); ил тод байдал (transparency), нээлттэй байдал (openness)-ын нэг бүрэлдэхүүн хэсэг юм (OECD 2011). Харин НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн засаг ба Нийгмийн Комисс ил тод байдлыг сайн засаглалыг илэрхийлэх найман шинж байдлын нэг юм гэж үзээд энэ нь нээлттэй байдал гэсэн ойлголтоос тусдаа болохыг тэмдэглэсэн байдаг. Мөн бидний мониторингидоо гол мөрдлөг болгон ашиглаж буй 143 дугаар тогтоол нь “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” хэмээн нээлттэй байдлыг гэхээс илүүтэй ил тод байдлыг онцлон авч үзсэн байна. Эдгээр шалтгаанууд дээр үндэслэн мониторинг нь энэ удаад төрийн байгуулагын “ил тод” байдлыг онцлон шинжлэх юм.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолтоор ил тод байдал гэдэг нь “төрийн байгуулагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь найдвартай, холбогдолтой, цаг үеийн байдлаар олон нийтэдхүрч байгааг хэлнэ”(OECD 2011). Харин НҮБ-ын ази, номхон далайн эдийн засаг ба Нийгмийн комисс: “Ил тод байдал гэдэг нь төрөөс гаргаж буй шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь уг шийдвэрийн нөлөөлж буй хэнд ч чөлөөтэй, хүртээмжтэй байхыг хэлнэ” гэжээ(UNESCAP 2011).

1.3. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд

Уг мониторингийн арга зүйд ашиглагдсан үндсэн шалгуур үзүүлэлтүүд нь тухайн төрийн байгууллага хэр ил тод байгааг хэмжихэд чиглэгдсэн. Хэдийгээр ил тод байдлыг хэмжих олон янзын шалгуур үзүүлэлт байдаг ч (тухайлбал улс төрийн өнцгөөс, эдийн засгийн, хэвлэл мэдээллийн, хүний эрхийн, бизнесийн өнцгөөс үнэлэх шалгуур гэх мэт) энэ удаад үндсэн хоёр чиглэлээр шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Үүнд:

- Нэгдүгээрт, Тогтоолд тусгагдсан мэдээллийн ил тод байдлыг хангах үндсэн дөрвөн хүрээ болох “Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал”, “Хүний нөөцийн бодлогын ил тод, нээлттэй байдал”, “Төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдал”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал” гэсэн мэдээллийн хүрээг авч үзсэн.
- Хоёрдугаарт, улсын болон төрийн байгууллагын вэбсайтад тавигддаг олон улсад хэрэглэгддэг нийтлэг шаардлага, стандарт үзүүлэлтэд тулгуурласан болно.

Шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа ХЭМЖИГДЭХҮЙЦ, ХЭРЭГЖИХҮЙЦ бөгөөд БОДИТОЙ байх зарчмыг баримталсан болно. Түүнчлэн мэдээллийн агуулгын шинжилгээг хийх нийтлэг шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага ил тод байдлыг тодорхойлохдоо ашигласан үндсэн гурван шалгуур үзүүлэлт, НҮБ-ын Ази, номхон далайн эдийн засаг ба Нийгмийн комиссын ашигласан нэг шалгуур үзүүлэлтийг хослуулан, дээрээс нь ил тод байдлыг гэхээсээ илүүтэй вэбсайтуудын чанарыг үнэлэхэд өргөн ашиглагддаг стандарт үзүүлэлтийг нэмжк нийт таван шалгуур үзүүлэлт бүхий мониторингийн дизайныг боловсруулсан болно.

Шалгуур үзүүлэлт 1. Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance): Төрөөс иргэдэд үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг хүртэх боломжтой байдал. Нарийвчилбал тухайн вэбсайт нь ЗГ-ын 143 дугаар тогтоолд вэбсайтад тавигдсан байхаар заасан дөрвөн хүрээний дагуух 28 төрлийн мэдээллүүдийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэхийг хэмжинэ.

Шалгуур үзүүлэлт 2. Мэдээллийн найдвартай байдал (Reliability): Тухайн вэбсайт дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэхийг илэрхийлнэ (Alanezi, Kamil and Basri 2010). Мөн Тогтоол дахь дөрвөн хүрээний дагуух 28 төрлийн мэдээлэл хэр найдвартай байгааг хэмжинэ.

Шалгуур үзүүлэлт 3. Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness): Вэбсайтад цаг үеийн, ач холбогдоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэхийг хэмжинэ (Harris 2010). Өөрөөр хэлбэл төрөөс иргэдэд хүргэж буй мэдээлэл цагаа үе олсон, тогтмол давтамжтай шинэчлэгддэг бөгөөд уг мэдээллийг хэрэглэгчид хүлээн авах хийгээд ашиглах боломжтой байдлыг хянах юм.

Шалгуур үзүүлэлт 4. Вэбсайтын хүртээмжтэй байдал (Accessibility): Вэбсайт нь хэрэглэгчид төрийн байгууллагуудад шууд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломж олгосон, хоёр талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг хэмжинэ (Drew and Nyerges 2004, 57).

Ингэхдээ дээрх гурван шалгуур үзүүлэлтээс ялгаатай нь мэдээллийн агуулгад бус вэбсайтад өөрт нь холбогдох хэмжүүрийн дагуу шинжилгээ хийх юм.

Шалгуур үзүүлэлт 5. Хэрэглэхэд хялбар байдал (Usability): Хэрэглэгчид тухайн вэб хуудсыг хэрэглэхэд хялбар байгаа эсэх. Үүнд вэбсайтын туслах хэрэгслүүд, үзэмж, төрх, дизайн зэрэг багтана (Weakley 2004). Аливаа вэбсайт нь иргэдийн интернэтийн хэрэглээний чадварт нийцсэн, энгийн, ойлгомжтойбайх нь хэрэглэхэд хялбар байдлыг илтгэх чухал үзүүлэлт болдог.

Дээрх үндсэн таван шалгуур үзүүлэлтийн тусlamжтайгаар төрийн байгууллага вэбсайтаараа дамжуулан 143 дугаар тогтоолд заасан үндсэн дөрвөн хүрээний мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгааг хэмжих юм. Тэгэхээр бидний мониторингидоо сонгон авсан шалгуур үзүүлэлт, тэдгээрийг тус бүр хэмжих хэмжүүрийг Хүснэгт 1-ээс харж болно.

Хүснэгт1 Мониторингийн шалгуур үзүүлэлтуүд

Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт	Хэмжүүр	Хүрээ
Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance)	Тухайн вэбсайт нь ЗГ-ын 143 дугаар тогтоолд заасан мэдээллүүдийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэх	Мэдээлэл цогц бүрэн байгаа эсэх	Үйл ажиллагаа Хүний нөөц Төсөв, санхүү байдал Худалдан авах ажиллагаа
Мэдээллийн найдвартай байдал (Reliability)	Тухайн вэбсайт дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэх	Мэдээллийн эх сурвалж тодорхой байгаа эсэх	Хүний нөөц Төсөв, санхүү байдал Худалдан авах ажиллагаа
Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness)	Вэбсайт цаг үеийн, ач холбогдоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэх	Тухайн мэдээллийг оруулсан хугацаа тодорхой эсэх Тухайн мэдээлэл хэрэглэгчдэд зориулж боломжит хугацаанд нийтлэгдэж байгаа эсэх	Хүний нөөц Төсөв, санхүү байдал Худалдан авах ажиллагаа Хүний нөөц Төсөв, санхүү байдал Худалдан авах ажиллагаа
		Тухайн мэдээлэл тогтмол шинэчлэгддэг эсэх	Хүний нөөц Төсөв, санхүү байдал Худалдан авах ажиллагаа

Вэбсайтын хүртээмжтэй байдал (Accessibility)	Вэбсайт нь хэрэглэгчид төрийн байгууллагаас шууд хандан мэдээлэл авах боломж олгосон мөн 2 талын оролцоог хангасан эсэх	Асуулт хариултын булан байгаа эсэх Хэлэлцүүлгийн булан байгаа эсэх Холбоотой байгуулагын холбоос линк байгаа эсэх Тогтмол асуудаг асуултуудын хариулт байгаа эсэх (FAQ) Хэлний сонголт байгаа эсэх	
	Сайтын үсгийн фонт тохиромжтой, харагдахуйц байгаа эсэх		
	Сайтын цэс ойлгомжтой эсэх		
	Сайтанд өнгөний зохицол байгаа эсэх		
Вэбсайтын хэрэглэхэд хялбар байдал (Usability)	Хэрэглэгчдэд тухайн вэбсайтын бүтэц, дизайн, үзэмж зэрэг нь ашиглахад хялбар байгаа эсэх	Сайтын бүх мэдээлэл нь нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байгаа эсэх Сайтаас мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай программыг татаж авах боломжтой байгаа эсэх Дурын броузерээс тухайн сайт руу орох боломж байгаа эсэх Сайтанд алдаа гарч байгаа тохиолдолд шийдэх арга замыг зааж өгч байгаа эсэх Сайтад хайлтын цэс байгаа эсэх Сайтанд сайтмал байгаа эсэх Сайтаас хэвлэх боломж байгаа эсэх Сайтанд файлыг хадгалах боломж байгаа эсэх Сайтнаас мэдээллийг бусдад илгээх боломж байгаа эсэх	
		Сайтаас мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай программыг татаж авах боломжтой байгаа эсэх	
		Дурын броузерээс тухайн сайт руу орох боломж байгаа эсэх	
		Сайтанд алдаа гарч байгаа тохиолдолд шийдэх арга замыг зааж өгч байгаа эсэх	
		Сайтад хайлтын цэс байгаа эсэх	
		Сайтанд сайтмал байгаа эсэх	
		Сайтаас хэвлэх боломж байгаа эсэх	
		Сайтанд файлыг хадгалах боломж байгаа эсэх	
		Сайтнаас мэдээллийг бусдад илгээх боломж байгаа эсэх	
		Сайтнаас мэдээллийг бусдад илгээх боломж байгаа эсэх	
		Сайтнаас мэдээллийг бусдад илгээх боломж байгаа эсэх	

Онцлон тэмгдэглэхэд хэдийгээр 143 дугаар тогтоолд заасан мэдээллийн зарим хүрээ, тухайлбал хүний нөөц, төсөв, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл нь тухайн төрийн байгууллагын албан ёсны вэбсайтаас тусдаа нэгдсэн вэбсайтад байрладаг боловч вэбсайт бүр дээр өдгөөр мэдээллийг тавихад хориглох зүйлгүй гэж үзэн мониторингийн үнэлгээнд хамруулсан болно. Жишээлбэл, аль нэг төрийн байгууллагын вэбсайтад хүний нөөцийн талаарх мэдээлэл шууд тавигдаагүй боловч энэ талаарх мэдээллийг авч болох холбоос (Төрийн албаны зөвлөлийн холбоос гэх мэт), холбогдох албан тушаалтны хаяг зэрэг багтсан байвал хүний нөөцийн хүрээний мэдээлэл агуулагдсан хэмээн үнэлэх боломжтой юм. Ингэснээр вэбсайтуудыг шалгуурын нэгдсэн түвшинд хамруулж олон төрлийн вэбсайтыг хооронд нь харьцуулах боломжтой болсон юм .

1.4. Мониторингийн мэдээлэл цуглуулах, боловсруулах арга

Мэдээлэл цуглуулах арга. Олон төрлийн дизайн, мэдээллийн агууламж бүхий вэбсайтуудад мэдээллийн агуулгын шинжилгээ хийж харьцуулахын тулд ил тод байдлыг тодорхойлох нийтлэг шалгуур үзүүлэлт тус бүрийг хэмжих хэмжүүрүүд, асуултын чиглэлийг нарийвчлан тодорхойлсон асуултгандаа нийт 100 төрийн байгууллагын вэбсайтад зочилж шинжилгээ хийсэн.

Мэдээлэл боловсруулах арга. Ажиглалтын явцад цуглуулсан мэдээллийг Excel програмд шивж нэгтгээд, логик алдааг магадлан, мэдээллийн санг цэвэрлэсний эцэст тоон


мэдээллийн шинжилгээний SPSS (Statistical Programm for Social Science) 17.0 програмыг ашиглан боловсруулалт хийсэн.

Мэдээлэлд шинжилгээ хийсэн арга. Үндсэн арга бол харьцуулалтын, эрэмбэлэлтийн аргууд юм.Хамрагдсан төрийн байгуулагын вэбсайтыг ил тод байдлын үзүүлэлтээр нь эрэмбэлж жагсаалт гаргах нь мониторингийн нэг зорилт юм. Ил тод байдлын хэрэгжилтийг үнэлсэн юм. Үндсэн дөрвөн хэлбэрээр шинжилгээг гаргасан нь:

1. Тухайн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт вэбсайтад ямар түвшинд байгааг хэмжүүр тус бүрээр хувиар гаргаж үнэлэх
2. Өнгөрсөн онтой харьцуулагдахуйц шалгуур үзүүлэлтүүдээс гарсан үр дүнг 2010 оны мониторингийн үр дүнтэй харьцуулан дүгнэх
3. Мониторингийн хавсралт хэсэгт байгууллага тус бүрээр шалгуур үзүүлэлтүүдээс авсан оноо, хувиар нь хооронд нь эрэмбэлэх
4. Төрийн байгууллагын вэбсайтуудыг үйл ажиллагааны онцлогоор нь тус бүрт нь эрэмбэлж, хавсралт хэсэгт оруулах явдал байлаа.

2010 онтой харьцуулахад энэхүү мониторингийн арга зүйн гол онцлог гэвэл вэбсайтын ил тод байдлыг үнэлэх үнэлгээний аргыг боловсронгуй болгосон. Тодруулбал, өмнөх оны мониторингийн арга зүйд ашиглагдсан шалгуур үзүүлэлт бүгд хоорондоо ач холбогдолын хувьд эн тэнцүү байсан бол энэ удаад үндсэн таван шалгуур үзүүлэлтийн аль нь ил тод байдлыг илтгэхэд илүү ач холбогдолтой үзүүлэлт вэ гэдгийг ялгаатай байдлаар тогтоож өгсөн. Эдгээр шалгуур үзүүлэлтийн нийт үнэлгээний системд эзлэх ач холбогдолын хувийг Дүрс 1-ээс харна уу.

Дүрс1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эзлэх хувь



Мэдээллийн холбогдолтой байдал мэдээллийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдээс хамгийн өндөр хувь буюу 30%-ийг эзэлж байгаа. Энэ нь вэбсайтад Тогтоолд заасан мэдээллийн бүх хүрээ ямар нэг байдлаар тавигдсан байгааг илтгэнэ. Тиймээс энэ нь ил тод байдлыг үнэлэх хамгийн үндсэн үзүүлэлт болно юм. Харин тухайн мэдээлэл нь чанарын хувьд ямар мэдээлэл байна вэ гэдэг дээр хоёр шалгуур үзүүлэлт байгаа бөгөөд нийт үнэлгээний системд тус бүр 20 хувь, нийлээд 40 хувь эзэлнэ (мэдээллийн найдвартай ба цаг үеийн байдлын шалгуур үзүүлэлтүүд). Эцэст нь мэдээлэл

хэрхэн хүрч байна вэ гэдэгт вэбсайтын хүртээмжтэй байдал, хэрэглэхэд хялбар байдал багтсан бөгөөд эдгээр нь илүү хэлбэрийн шинжтэй үзүүлэлт тул нийт үнэлгээний системд тус бүр 15 хувь (мэдээллийн хүртээмжтэй байдал ба хэрэглэхэд хялбар байдал), нийт 30 хувийг эзэлж байна.

Мөн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг үнэлэхдээ өмнөх мониторингийн арга зүйд ашигласан шалгуурыг хангасан, хангаагүй гэсэн үнэлэлт дээр хоёр үнэлгээний нэмсэн. Өөрөөр хэлбэл тухайн шалгуур үзүүлэлтийг хэдэн хувьтай биелүүлснээс хамаарч төрийн байгууллагын вэбсайтын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тоон утгаар хэмжих оролдлого хийсэн гэсэн үг юм. Хэмжилтээр гарч ирсэн үр дүнг тухайн шалгуур үзүүлэлт тус бүрээр уг мониторингийн ажилд хэрхэн ойлгож тайлбарлаж байгаа вэ гэдгийг дараахь хүснэгтээс харж болно.

Хүснэгт2 Тухайн шалгуурыг ямар хэмжээнд хангаж байгааг үнэлэх үнэлгээ

Хувь	Холбогдолтой байдал	Найдвартай байдал	Цаг үеийн байдал	Хүртээмжтэй байдал	Хэрэглэхэд хялбар байдал	Ил тод байдал
81-100	Бүрэн холбогдолтой	Мэдээлэл бүрэн найдвартай	Тогтмол шинэчлэгдээг мэдээлэл	Бүрэн хүртээмжтэй	Хэрэглэхэд маш хялбар	Бүрэн ил тод
61-80	Холбогдолтой	Найдвартай	Ихэнхи мэдээлэл шинэчлэгдэг	Хүртээмжтэй	Хэрэглэхэд боломжтой	Ил тод
41-60	Зарим талаар холбогдолтой	Зарим талаар найдвартай	Зарим мэдээлэл шинэчлэгдэг	Зарим талаар хүртээмжтэй	Хэрэглэхэд төвөгтэй	Зарим талаар ил тод
0-40	Мэдээлэл огт байхгүй эсвэл холбогдолгүй	Найдваргүй	Хоцрогдсон мэдээлэл	Хүртээмжгүй	Хэрэглэхэд маш төвөгтэй	Хаалттай

1.5. Мониторингийн хамарсан хүрээ, цаг хугацаа

Мониторингийн 2011 оны 11 сарын 23-аас 2011 оны 12 дугаар сарын 31-ны өдрүүдэд хийлээ. Монгол улсын 100 төрийн байгууллага хамрагдсан. Өмнөх онтой харьцуулахад 25-аар илүү бөгөөд шинээр шүүх эрх мэдлийн болон Улсын Их Хурлын харьяа байгууллагууд хамрагдav. Тодруулбал судалгаанд:

- Монгол улсын яам -11;
- Монгол улсын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлаг -43;
- Монгол улсын орон нутгийн захиргаа- 21;
- Монгол улсын шүүх эрх мэдлийн байгууллага- 14;
- Улсын Их Хурал болон түүний харьяа байгууллагууд -11 тус тус багтсан болно.

Ингэхдээ мониторингийн Мэдээлэл цуглуулах үе шат нь 2011 оны 12 сарын 3-11-ний хооронд хийгдсэн бөгөөд яг энэ цаг хугацаанд ажиллаж байсан нийт 96 вэбсайтад шинжилгээ хийсэн болно. Шинжилгээнд хамрагдаагүй 4 вэбсайт нь Дорнод аймгийн вэбсайт, Баянхонгор аймгийн вэбсайт, Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны вэбсайт, Орхон аймгийнх тус тус болно. Хандалт хийхэд нэвтрэх боломжгүй байсан вэбсайтуудад мэдээлэл цуглуулах хугацаанд өдөр бүр нэвтрэх оролдлого хийж байсан. Үүнтэй зэрэгцэни www.ptis.gov.mn сайтад хандан тухайн байгууллагын холбоос линкээр нэвтрэх,

www.google.mn сайтад байгууллагын нэрийг бичин хайлт хийж нэвтрэх оролдлогыг мэдээлэл цуглуулах судлаачид хийсэн болно.

2011 оны мониторингийн арга зүй нь 2010 оны мониторингийн арга зүйг сайжруулан боловсруулсан хувилбар юм. Хүснэгт 3-т хоёр оны мониторингийн арга зүйг багцлан харьцууллаа.

Хүснэгт 3 2010 ба 2011 оны вэб мониторингийн арга зүйн харьцуулалт

Харьцуулах үзүүлэлт		Вэб мониторинг-2010	Вэб мониторинг- 2011
1	Мониторингийн хамрах хүрээ	75 вэбсайт	100 вэбсайт
2	Ашиглагдсан шалгуур үзүүлэлт	<p>Нийт 3 шалгуур үзүүлэлт:</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээллийн нээлттэй байдал (Openness) • Мэдээллийн үр ашигтай байдал (Effectiveness) • Мэдээллийн хүртээмжтэй байдал (Accessibility) 	<p>Нийт 5 шалгуур үзүүлэлт:</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээллийн холбогдолтой байдал • Мэдээллийн найдвартай байдал • Мэдээллийн цаг үеийн байдал • Вэбсайтуудын хүртээмжтэй байдал • Вэбсайтуудын ашиглахад хялбар байдал
3	Шалгуур үзүүлэлтүүдийн хоорондын харьцаа	<p>Мэдээллийн нээлттэй байдал- 33,3%</p> <p>Мэдээллийн үр ашигтай байдал -33,3%</p> <p>Мэдээллийн хүртээмжтэй байдал- 33,3%</p> <p>Нийт-100%</p>	<p>Мэдээллийн холбогдолтой байдал-30%</p> <p>Мэдээллийн найдвартай байдал- 20%</p> <p>Мэдээллийн цаг үеийн байдал- 20%</p> <p>Вэбсайтуудын хүртээмжтэй байдал- 15%</p> <p>Вэбсайтуудын ашиглахад хялбар байдал -15%</p> <p>Нийт-100%</p>
4	Үнэлгээний систем	Үнэлгээг нийт бүх мэдээлэл тухайн үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан ба хангаагүй гэсэн 2 ангиллаар хийсэн.	Үнэлгээг тухайн шалгуур үзүүлэлтийн хэмжүүр тус бүр дээр нийт хэдэн хувийг нь хангаж байгаагаас хамаарч 4 ангиллаар хийсэн.

БҮЛЭГ 2. МОНИТОРИНГИЙН ГОЛ ҮР ДҮН: ВЭБСАЙТУУДЫН ИЛ ТОД БАЙДАЛ

2.1 МЭДЭЭЛЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ БАЙДАЛ

Мэдээллийн холбогдолтой байдлын шалгуур үзүүлэлтийг тухайн вэбсайт нь Засгийн газрын 143 дугаар тогтоолд заасан мэдээллийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэхийг мэдэхэд гол зорилго болгон ашиглав. Тиймээс Тогтоолд заасан мэдээлэл тухайн вэбсайтад бүрэн байгаа эсэхийг 1. Байгууллагын үйл ажиллагааны, 2. Хүний нөөцийн, 3. Төсөв санхүүгийн, 4.Худалдан авах ажиллагааны гэсэн дөрвөн хүрээнд хийлгээ. Үүнийг 2010 оны үр дүнтэй харьцуулан өсөлт ба бууралтыг нь тайлбарлав.


2.1.1 Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн холбогдолтой байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ байгууллагын талаарх 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл, 2. Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилав. Одоо эдгээрийг тус тусад нь авч үзье.

Байгууллагын ерөнхий мэдээлэл. Төрийн байгууллагын вэбсайтанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан байгууллагын хувьд эрхэм зорилгоо тавьсан байдал 2010 онд 70.8 хувьтай байсан бол 2011 онд 53.1 хувь болж 17.7 хувиар буурчээ.

Байгууллагын вэбсайтад доорх мэдээлэл байна уу?

Дүрс2. Байгууллагын ерөнхий мэдээлэл




Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг вэбсайтанд мэдээлсэн байдал нь мөн өнгөрсөн оныхос 12.1 хувиар багассан байна. Мөн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг мэдээлсэн байдал 35.4 хувиас 20.8 хувь болж буурчээ. Харин албан хаагчийн ёс зүйн дүрмийг нийтлэх нь өнгөрсөн онд дөнгөж 16.9 хувьтай байсан бол 2011 онд 45.8 хувьтай болж өсчээ. Дээрх дүрсээс харахад байгууллагын үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг харуулах дөрвөн үзүүлэлтээс гурав нь буюу эрхэм зорилго, үйл ажиллагаа стратегийн

зорилго зорилт мөн албан хаагчийн ёс зүйн дүрэм нь зарим талаар хангалттай тавигдсан гэсэн ангилалд орж байгаа бол үлдсэн нэг үзүүлэлт болох тэргүүлэх чиглэл нь хангалтгүй гэсэн ангилалд багтаж байна.

Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл. Байгууллагын олон нийттэй харьцах мэдээллийг Дүрс 3-т харуулсан 7 үзүүлэлтээр хэмжсэн болно. Өнгөрсөн жилтэй харьцуулахад тухайн байгууллагын олон нийттэй харьцах мэргэжилтний овог нэрийг мэдээлэх байдал 26.2 хувиас 57.3 хувь болж сайжирчээ. Мөн тухайн байгууллагын шуудангийн хаяг нь тавигдсан байдал нь 6.2 хувиас 26 хувь болж нэмэгдсэн бол байгууллагын хаяг, байгууллагатай холбоо барих утас, факсын дугаар зэрэг нарийвчилсан мэдээлэл бага зэрэг өсчээ.

Дүрс 3. Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл




Харин иргэдийг хүлээн авах цагийн хуваарь, тухайн вэбсайтаас шууд холбогдох боломж бага зэрэг буурсан байна. 2011 оны байдлыг дүгнэн үзвэл эдгээр долоон үзүүлэлтийн хувьд гурван үзүүлэлт нь хангалтгүй, нэг үзүүлэлт нь зарим талаараа хангалттай, дөрвөн үзүүлэлт нь бүрэн хангалттай гэсэн үнэлгээ авч байна.

2.1.2 Хүний нөөцийн мэдээллийн холбогдолтойбайдал

Хүний нөөцийн ил тод байдлыг бид тухайн байгууллага сул орон тооны зараа вэбсайтандaa хэрхэн тавьж байгаа хянаж үзсэн. Хэдийгээр сул орон тооны зарыг төрийн албаны холбогдох хуулиар тусгай вэбсайтанд зарлах ёстой боловч мөн тухайн үндсэнбайгууллагын вэбсайтанд зарлахыг ач холбогдолтой гэж мониторингийн баг үзсэн. Ийм зарласан сул орон тооны зар 80 хувиас 18.8 хувь болж буурчээ.

Дүрс4. Хүний нөөцийн ил тод байдал



Иргэдийн хувьд төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт өнгөрсөн оныхоос даруй 6.9 хувиар өссөн бол байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мөрдөж буй хууль тогтоомжийг вэбсайтанд байрлуулсан байдал 66.2 хувиас 78.1 хувь хүртэл өссөн, дүрэм журам, заавар 70 хувиас 75 хувь болтлоо ихэсчээ.

Дүрс5. Байгууллагатай холбоотой материал



Дүгнэвэл хүний нөөцийн ил тод байдлыг илтгэх дүрс 4 ба 5 дээрх дөрвөн үзүүлэлтийн хувьд хоёр үзүүлэлт нь хангалттай гэсэн ангилалд багтаж байгаа бол нэг үзүүлэлт нь зарим талаараа хангалттай, харин сул орон тооны үндсэн үзүүлэлт нь хангалтгүй гэсэн ангилалд оржээ.

2.1.3 Байгууллагын төсөв, санхүүгийн мэдээллийн холбогдолтойбайдал

Төрийн байгууллагын вэбсайтанд байгууллагын төсөвтэй холбоотой зургаан баримт бичгийг тавьсан байгаа эсэхийг шалгасан бөгөөд хоёр оноор харьцуулан харахад дараахь байдалтай байна. Өнгөрсөн жилээс ялгаатай нь төслийн гүйцэтгэлийн биелэлт гэсэн баримт бичгийг 2011 онд нэмж шинжилсэн. Үүнд байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төслийн гүйцэтгэл ба дараа жилийн төсвийн төслийг тавих нь бага хувиар ч гэсэн ёсчээ.

Дүрс6. Байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдал




Эсрэгээрээ хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан ба санхүүгийн тайланд хийсэн аудитийн дүгнэлтийн мэдээлэл багассан байна. Дүгнэн үзвэл төсөв санхүүтэй холбоотой баримт бичгүүдийг вэбсайтанд байрлуулах нь өнгөрсөн жил ба энэ жилийн аль алинд нь бага байгаа бөгөөд цаашид үүнийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

2.1.4 Худалдан авах үйл ажиллагааны мэдээллийн холбогдолтойбайдал

Байгууллагын худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг таван үзүүлэлтээр авч шинжилсэн. Өнгөрсөн оноос ялгаатай нь энэ удаад худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг харуулсан үзүүлэлтийг нэмж оруулсан. Хэдийгээр худалдан авалтын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь холбогдох хуулиар тусдаа вэбсайтанд тавигдах ёстой боловч тухайн байгууллагын вэбсайтанд холбогдох мэдээллийг тавихад хориглох зүйлгүй гэж үзлээ.

Өнгөрсөн онтой харьцуулбал эдгээр долоон үзүүлэлтээс тендерийн урилгыг л вэбсайтанд мэдээлэх явдал 2.6 хувиар өссөн. Харин бусад дөрвөн үзүүлэлт буюу хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ, тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл, худалдан авсан бараа үйлчилгээний тайлан зэрэг үзүүлэлт нь бараг хоёр дахин буурчээ.

Дүрс 7. Худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал



2010, 2011 оны мониторингийн аль алинд нь худалдан авах үйл ажиллагааны мэдээллийг бүрэн тавьж байгаа эсэхийг харуулах үзүүлэлт хангартгүй гэсэн ангилалд багтаж байна.



Дэд бүлгийн эцест мэдээллийн холбогдолтой байдлын шалгуур үзүүлэлтийг хамгийн сайн хангасан, эхний гурван байранд орсон вэбсайтыг онцолж байна.

Хүснэгт 4 Мэдээллийн холбогдолтой байдлын эхний 3 байр эзэлсэн вэбсайт

Байр	Байгууллагын нэр	Нийт бөглөгдсөн	Хувь
1	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам	20	71.43
2	Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар	18	64.29
2	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	18	64.29
3	Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам	15	53.57
3	Улсын бүртгэлийн ерөнхий газар	15	53.57

Мэдээллийн холбогдолтой байдал нь нийт бөглөгдөх ёстой 28 үзүүлэлттэй бөгөөд төрийн байгууллагын вэбсайтуудыг хэдэн үзүүлэлтийг хангаснаар нь байр эзлүүлсэн. Хамгийн сайн үр дүнг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам 20 үзүүлэлтийг хангасан буюу 71.43 хувиар авсан бол хамгийн муу үр дүнг Сонгуулийн ерөнхий хороо 3 хариулт буюу 10.71 хувиар үзүүлсэн байна.

Зураг 1. НХХЯ-ны вэбсайт

The screenshot shows the homepage of the 'NHHYA' website. At the top, there's a navigation bar with links like 'НҮҮР ХУУДАС', 'ҮЙЛ АЖИЛЛАГАА', 'ҮЙЛЧИЛГЭЭ', 'МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ', 'ХУУЛЬ, ТОГТООМЖ, ШИЙДВЭР', 'ХОЛБОО БАРИХ', and 'ЦАХИМ ШУУДАН'. Below the navigation, there's a search bar with placeholder text 'НҮҮР ХУУДАС' and 'ЭР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЖИЛ'. The main content area has a large image of a white bus with 'NHHYA' on its side. To the right, there's a list of news items and a large trophy icon with the text 'НАРНЫ ЦОМ-2011'.

Уг хуудсанд байгууллагын үйл ажиллагааны зорилго, чиглэл, үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомж зэргийг тавьсан байгааг харж болно.

Зураг 1. Сонгуулийн ерөнхий хорооны вэбсайт

The screenshot shows the homepage of the General Election Commission of Mongolia's website. At the top, there are navigation links: Нүүр хуудас (Home), Сайтын бүтэц (Site map), Мэдээ мэдээлэл (Information), and Асуулт хариулт (Feedback). The main header is 'СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО'. On the right, there is a link to 'Монгол | English'. Below the header, there is a large photo of a man in a suit sitting at a desk, with the Mongolian flag and a small emblem in the background. To the left, there is a sidebar with various links:

- Өнөөдөр 2012.01.06
- > Танилцуулга
 - Чиг үүрэг
 - Бүтэц тогтолцоо
 - Буралдхүүн
 - Балгз тэмдэг
- > Хувь тогтоомж
 - Хувь
 - Эрх зүйн баримт бичиг
 - > Сонгуулийн ажлын цаг хугацааны хуваарын
Ерөнхийлөгчийн
сонгуулийн
 - УИХ-ын сонгуулийн
 - ОНХ-ын сонгуулийн
- > Улс төрийн намууд
- > Нэр дэвшигчид
 - 2004 он
 - 2008 он
- > Олон улсын сонгуулийн хуанли
- Гадаад орнуудын сонгуулийн төв байгууллагууд
- Сонгуулийн дүн
 - УИХ сонгууль
 - 1992 он
 - 1996 он
 - 2000 он
 - 2004 он
 - 2008 он
- Ерөнхийлөгчийн сонгууль

The main content area includes a section titled 'Мэндчилгээ' with a photo of a man in a suit, followed by text about the election process and results. There is also a sidebar with links related to the election commission's work and history.

Уг хуудсанд эдийгээр байгууллагын танилцуулга, хууль тогтоомж, байгууллагын онцлогтой холбоотой мэдээлэл байгаа ч гэсэн зорилго, зорилт, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээлэл тавигдаагүй болох нь харагдаж байна.

2.2 МЭДЭЭЛЛИЙН НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

Мэдээллийг баттай эх сурвалжаас гаргасан, үнэн зөв, тодорхой баримт сэлттэй байгаа үед найдвартай мэдээлэл гэж үздэг. Мэдээллийн найдвартай байдал гэдэг нь итгэл даахаар, үнэн гэсэн утгыг агуулдаг тул мэдээлэл нь хэрэв итгэл даахааргүй бол найдваргүй гэж ойлгогдоно.

Мэдээллийн найдвартай байдал (reliability) гэсэн шалгуур нь тухайн вэбсайт дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэхийг шалгана (Alanezi, Kamil and Basri 2010). Үүнийг Засгийн газрын 143-р тогтоолд заасан мэдээллүүд ямар нэг эх сурвалжтай байна уу үгүй юу гэдгээр хэмжсэн юм. Ингэдхээ тухайн мэдээлэлд дараах эх сурвалжууд бүгд эсвэл дор хаяж нэг нь байгаа эсэхээс хамааруулан мэдээллийг эх сурвалжтай, эх сурвалжгүй буюу найдвартай, найдваргүй хэмээн ангилсан:

1. Мэдээг оруулсан хүний нэр, овог
2. Албан тушаал
3. Хэлтэс
4. Хаяг
5. Утас
6. И-мэйл хаяг
7. Байгууллагын нэр
8. Холбоос линк.

Мэдээллийн найдвартай байдлын шалгуур үзүүлэлтээр Засгийн газрын 143 дугаар тогтоолын хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдлын нийт 11 үзүүлэлтийг хэмжсэн. Харин байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэлд дээрх 8 эх сурвалж заавал дурдагдсан байх шаардлагагүй, тухайн төрийн байгууллага өөрөө эх сурвалж болно гэж үзсэн болно.


2.2.1 Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн найдвартай байдал

Уг мониторингийн хүрээнд энэхүү бүлгийн мэдээлүүдийг заавал баттай эх сурвалж, тоо баримт дурьдагдах шаардлагагүйгээр найдвартай мэдээлэл гэж үзсэн. Учир нь эдгээр мэдээлүүд тухайн байгууллагын вэбсайтад байгаа бол баттай эх сурвалж болж, тоо баримт дурьдагдаж байгаа нь ч гэсэн баримттайолж байгаа юм. Энэ хүрээг дэд бүлгийн хүрээнд дүгнэлт, хүснэгтэнд оруулж тооцохгүйгээр хэмжих боломжгүй, тухайн утгад хамааралгүй гэж үзсэн.

2.2.2 Хүний нөөцийн бодлогын мэдээллийн найдвартай байдал

Тогтоолын хүний нөөцийн бодлогын ил тод байдлын шалгуур үзүүлэлтэнд байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги, түүний хэрэгжилтийн явц, үр дүн нээлттэй, ил тод болсон байна гэж үзсэн байдаг. Төрийн байгууллагын вэбсайтын мониторингийн хүрээнд сул орон тооны зарыг үнэлгээний шалгуур гэж авч үзэж байгаа бөгөөд эх сурвалж тодорхой байна уу гэдгийг шалгах юм.

Дурс8. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал



Мониторингид хамрагдсан төрийн байгууллагын вэбсайтын 14.6 хувьд нь сул орон тооны зар байгаа нь хангалтгүй, найдваргүй түвшинд хэрэгжиж байна гэж үзэхэр харагдаж байгаа юм. Гэвч төрийн байгууллага өөрсдийн хэрэгцээтэй албан хаагчдыг “төрийн албан хаагчийн шалгалт”-нд тэнцсэн хүмүүсээс сонгож авдаг нь төрийн байгууллагууд сул орон тооны зараа заавал вэбсайтад тавихгүй байж болох талтай болгодог. Иймээс сул орон тооны зарим төрийн байгууллагын вэб сайтад хангалтгүй гарч байгаа. Гэвч бидний зүгээс энэ талын мэдээллийг заавал байх ёстой гэж үзсэн.

2.2.3 Төсөв санхүүгийн мэдээллийн найдвартай байдал

Тогтоолын хүрээнд төсөв санхүүгийн ил тод байдалд төрийн байгууллагын төсвийн гүйцэтгэлийн урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг мэдээллийг багтаасан байх хэрэгтэй гэж тусгасан байdag.

Байгууллагын санхүүгийн талаарх мэдээллийн найдвартай байдал нь тухайн жилийн төсөв ба урьд оны гүйцэтгэл зэргийг вэбсайтад тавихдаа зохион байгуулалтын нэгж /хэлтэс, газар, алба тасаг/-ээс ямар албан тушаалтан /нэр/, хэзээ /огноо/ уг мэдээг оруулснаар нь шалгах хэмжүүр болох юм.

[Дүрс9. Төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал](#)



Төрийн байгууллагын вэбсайтад хууль тогтоомжинд заасан төлбөр хураамжийн хэмжээний найдвартай байдал тухайн хэсэгтээ хамгийн өндөр буюу 9.4 хувьтай байгаа бол төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах хэсэг нь 0 хувьтай байна.

Нийт судалгаанд хамрагдсан байгууллагын төсөв, санхүүгийн мэдээллийн найдвартай байдал нь 10 хувьдаа ч хүрэхгүй байгаа нь энэ талын мэдээллийг байгууллага эх сурвалжгүй тавьдаг болохыг харуулж байна.

2.2.4 Худалдан авах ажиллагааны мэдээллийн найдвартай байдал

Энэхүү хэсэгт тогтоолын дагуу тендер, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийн найдвартай эсэхийг үнэлэх юм.

[Дүрс10. Худалдан авах ажиллагааны ил тод байдал](#)



Нийт төрийн 96 байгууллагын вэбсайтын 22.9 хувь нь найдвартай эх сурвалжаас тендерийн урилгын талаарх мэдээллийг түгээж байгаа бол худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн найдвартай буюу 1 хувьтай байна. Бусад мэдээллүүд болох худалдан авах бараа, ажил үйлчилгээний тайлан 5.2 хувь, тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл 12.5 хувь байна.

Нэгтгэн дүгнэхэд 11 үзүүлэлтээс “төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт” нь хамгийн бага буюу ямар ч хэмжигдэх хувь байхгүй байна. Энэ нь хэрэглэгчдэд төсвийн талаарх нэмэлт өөрчлөлт гарлаа гэхэд хаанаас уг мэдээлэл тавигдаж байгаа талаар тодорхойгүй, найдвартай мэдээлэл хүрч байгаа гэсэн уг юм. Харин тендерийн урилга 22.9 хувь буюу хамгийн өндөр байгаа нь хэрэглэгчдэд илүү найдвартай мэдээллийг өгч чадаж байгаа юм.

Дүрс11. Вэбсайт дахь мэдээллийн найдвартай байдал



Нийт төрийн байгууллагын вэбсайтын мэдээллийн найдвартай байдлыг 11 үзүүлэлтээр авч үзэхэд дунджаар 6.86 хувь байна. Ингэснээр мониторингийн шалгуурын дагуу төрийн байгууллагын вэбсайтын мэдээлэл найдваргүй гэж дүгнэж болохоор байна.

Мэдээллийн найдвартай байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах вэбсайт хамгийн өндөр оноог авсан байна.

Хүснэгт 5 Мэдээллийн найдвартай байдлын эхний 3 байрын вэбсайт

Байр	Байгууллагын нэр	Бөглөгдсөн байдал	Хувь
1	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	8	61.54
2	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	6	46.15
3	Сангийн яам	5	38.46
3	Говь-Сүмбэр аймаг	5	38.46
3	Авилгатай тэмцэх газар	5	38.46

Эдгээр төрийн байгууллагын вэбсайт нь нийт судалгаанд хамрагдсан 100, мониторингийн шинжилгээнд орсон 96 вэбсайтаас хамгийн өндөр оноо, хувийг авч чадсан хэрэглэгчдэд найдвартай мэдээллийг түгээдэг вэбсайтууд болж байгаа юм.

Энэхүү шалгуурт нийт 13 хариултыг бөглөх байсан бөгөөд ихэнхи буюу 59 вэбсайт нэг ч хариултыг бөглөөгүй гэсэн хариу гарч байна. Хамгийн олон хариултыг бөглөснөөс Ус, цаг уур, орчны шинжилгээний газар 8 буюу 61.54 хувиар шалгарсан.

Зураг 3. Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын вэбсайт

Уг байгууллагын вэбсайтанд тендерийн урилга байгаа бөгөөд шалгуурын хүрээнд мэдээлэл дэх эх сурвалжийг дурьдсан байгааг харж байгаа байх.

Харин хамгийн муу вэбсайтын жишээгээр Авто тээврийн газрын вэбсайтыг авлаа. Авто тээврийн газар нь нийт бөглөгдөх ёстой асуултыг 1 ч бөглөөгүй бөгөөд вэбсайтандaa хэрэглэгчдэд найдваргүй буюу эх сурвалжгүй мэдээллийг түгээж байгаа юм.

Зураг 4. Авто тээврийн газрын вэбсайт

Уг байгууллагын вэбсайтаас хийсэн ажлын талаарх мэдээллийг сонгон авахад мэдээлэл дээрх эх сурвалж байхгүй, эргээд энэ талын мэдээллийг хэнээс лавлах нь тодорхойгүй байв.

2.3 МЭДЭЭЛЛИЙН ЦАГ ҮЕИЙН БАЙДАЛ


Төрийн байгууллагынвэбсайтанд байгаа мэдээллийн цаг үеийн байдлыг тодорхойлох нь энэ хэсгийн гол зорилго байв. Ингэхдээ цаг үеийн байдал гэдгийг ач холбогдоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэх гэж тодорхойлов. Үүнийг нэгдүгээрт, тухайн мэдээлэл оруулсан хугацааг тавьсан эсэх, хоёрдугаарт, тухайн мэдээлэл ашиглагчдад зориулж боломжит хугацаанд нийтэлж байгаа эсэх, гуравдугаарт, тухайн мэдээлэл тогтмол шинэчлэгддэг эсэх гэсэн гурван шалгуураар авч үзэв.

Тогтоолд заасан мэдээллийн цаг үеийн байдлыг 1. Хүний нөөцийн тухай мэдээлэл, 2. Төсөв санхүүгийн мэдээлэл, 3. Худалдан авах ажиллагааны мэдээлэл гэсэн гурван салбарт нийтдээ 13 асуултаар шинжлэв. Эдгээр мэдээлэл нь тодорхой цаг хугацаанд, тогтмол шинэчлэгдэж байх ёстой юм. Тооцоололд бусад мэдээллийг оруулаагүй болно. Үүнийг 2010 оны үр дүнтэй харьцуулах боломжгүй тул зөвхөн энэ оноор харуулав.

2.3.1 Хүний нөөцийн тухай мэдээлэл

2011 оны байдлаар төрийн байгууллаудын вэбсайтанд хүний нөөцийн ил тод байдлын тухайн мэдээллийг оруулсан хугацааг тавьсан байдал нь 14.6 хувьтай, тухайн мэдээллийг ашиглагчид зориулж боломжит хугацаанд нийтэлж байгаа нь 10.4 хувьтай байна.

Дүрс12. Хүний нөөцийн тухай мэдээлэл




Үүнээс харахад судалгаанд хамрагдсан байгууллагууд хүний нөөцийн талаархи мэдээллийг вэбсайтдаа тавьдаггүй бөгөөд шаардлага хангахгүй байна.

2.3.2 Төсөв санхүүгийн мэдээлэл

Төрийн байгууллагын вэбсайтанд төсвийн ил тод байдалтай холбоотой долоон мэдээллийг оруулсан хугацаагаар нь харвал нийт 2.95 хувьтай тухайн мэдээллийг ашиглагчид зориулж боломжит хугацаанд нийтэлсэн байдал нь 2.35 хувьтай, тухайн мэдээлэл тогтмол шинэчлэгддэг байдал нь 4.95 хувьтай байна.

Дүрс13. Төсөв санхүүгийн мэдээлэл



Эдгээрээс эхний үзүүлэлтийн хувьд урьд оны төслийн гүйцэтгэл арай өндөр хувьтай байгаа бол хоёрдугаар үзүүлэлтээр тухайн жилийн төсөв бусдаасаа өндөр, гуравдугаар шалгуурын хувьд урьд оны төсөв 15.6 хувьтайгаар хамгийн өндөр байна.

Дүгнэвэл төрийн байгууллагын төсөвтэй холбоотой мэдээллийг цаг тухайд тавих явдал муу байгаа бөгөөд цаг үеийн биш хоцрогдсон гэсэн ангилалд орохоор байна.

2.3.3 Худалдан авах ажиллагааны мэдээлэл

Төрийн байгууллагын худалдан авах ажиллагааны тухай мэдээлэл цаг хугацаандаа орж байгаа эсэх нь ихээхэн чухал юм. Өмнө өгүүлсэнчлэн хэдийгээр төрийн байгууллагын худалдан авах ажиллагаа нь хуулиар тусдаа вэбсайтанд албан ёсоор зарлагддаг боловч бид тухайн байгууллагын вэбсайтанд мэдээлэх ёстой гэж үзсэн.

Дүрс14. Худалдан авах ажиллагааны мэдээлэл



Тиймээс дээрх мэдээллийг таван үндсэн үзүүлэлтээр авч үзэхэд тухайн мэдээллийг оруулсан хугацааг тавьсан байдал нь дунджаар 10.2 хувьтай бөгөөд тендэрийн урилга нь хамгийн их түгээмэл тавигддаг бол худалдан авалтын үйл ажиллагааны тайлан, дүгнэлттэй холбоотой баримт бичиг маш бага хувийг эзэлж байна.

Тухайн мэдээллийг ашиглагчид зориулж боломжит хугацаанд нийтэлсэн эсэх дээр тендэр шалгаруулалтын талаархи мэдээллийг тавьсан байдал 24 хувьтай байгаа бол бусад үзүүлэлтүүд нь эхний шалгуураас өндөр байна. Худалдан авалтын үйл ажиллагаа нь тогтмол шинэчлэгдэж байгаа эсэх дээр дунджаар 3.1 хувьтай буюу хамгийн бага болж байна.

Нэгтгэн дүгнэвэл төрийн байгууллагын худалдан авалтын ажиллагааны мэдээлэл цаг хугацааны хувьд хаалттай, ил тод бус гэсэн дүгнэлтийг хийж болох юм.

Хүснэгт 6 Мэдээллийн цаг үеийн байдлын эхний 3 байрын вэбсайт

Байр	Байгууллагын нэр	Бөглөгдсөн байдал	Хувь
1	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	22	64.71
2	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам	18	52.94
3	Авилгатай тэмцэх газар	12	35.29

Мэдээллийн цаг үеийн байдлыг судлах энэхүү хэсэгт хамгийн өндөр оноог Цаг уурын газар авсан бөгөөд энэ удаагийн жишээн дээр урьд дурьдсан төрийн байгууллагыг давтахгүйгээр Авилгатай тэмцэх газрыг авч байна.

Авилгатай тэмцэх газар нь энэхүү шалгуурын 3 дугаар байрт нийт 12 хариулт буюу 35,29 хувиар орсон бол хамгийн муугаар нийт вэбсайтын 54 нь огт хариултанд бөглөгдөөгүй хэмээн орсон байна. Муу байгууллагын жишээгээр УИХ-ын вэбсайтыг сонгон авлаа. Судалгааны явцад ажиглаж байхад Авлигатай тэмцэх газрын вэбсайт дээр олон төрлийн мэдээлэл болох илтгэл, ухуулга сурталчилгаа, мэдээ мэдээлэл, тайлан зэрэг ихээр байсан бөгөөд бүх мэдээллийн нийтлэгдсэн хугацааг тавьж байсан ба мэдээлэл нь тогтмол шинэчлэгдэж байсан бол УИХ-ын вэбсайт дэх мэдээлэл нь хэт хоцрогдож байсан. Ялангуяа тогтоолын хүрээнд тавигдах ёстой мэдээлэл огт тавигдаагүй байсныг анхаарах хэрэгтэй юм.

Зураг 5. УИХ-ын вэбсайт

Уг байгууллагын вэбсайт дахь мэдээллийн хугацаа хэтэрснийг харж болох бөгөөд шинэ мэдээлэл нэмэгдээгүй даруй 2 жил өнгөрсөн байгааг мөн харах боломжтой.

2.4 МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Төрийн байгуулагын вэбсайтуудын ил тод, нээлттэй байдлыг хангаж байгаа эсэхийг үнэлэх судалгаанд шалгуур үзүүлэлт болгон Нэгдсэн үндэсний байгууллагын Сайн засаглалын 8 шинжийн (UNESCAP 2011) шалгуураас хэрэглэсэн бөгөөд түүний нэг нь болох “Ил тод байдал” нь хэрэглэгчийн хувьд “мэдээлэл чөлөөтэй хүртэгдэх ёстой” гэсэн үндсэн зарчим дээр суурилсан юм.

Хүртээмжтэй байдлын (accessibility) шалгуур үзүүлэлтнүүхайн вэбсайт хэрэглэгчдэд төрийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг авахаар хүсэлт гаргах, авах боломж олгохуйц мөн 2 талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг багтаан ойлгоно (Drew and Nyerges 2004).

Энэ шалгуур үзүүлэлт нь илүү хэрэглэгчийн байр суурийг харуулж байгаа бөгөөд тухайн мэдээлэл төрийн байгууллагын вэбсайтад байгаа эсэхийг тодорхой шалгуураар шалгана. Шалгуур үзүүлэлтийг дараах үзүүлэлтээр хэмжив:

- Асуулт хариултын булантай эсэх
- Хэлэлцүүлгийн булантай эсэх
- Холбоотой байгууллагын холбоос линк тавигдсан эсэх
- Тогтмол асуудаг асуулт, хариулт (FAQ) байгаа эсэх
- Хэрэглэгчдэд мэдээлэл авах үүднээс хэлний сонголт хийх боломж байгаа эсэх.

Бусад шалгуур үзүүлэлтээс ялгаатай нь мэдээллийн хүртээмжтэй байдал нь мэдээллийн агуулгыг гэхээс илүүтэй тухайн вэбсайт дахь мэдээлэл хэр хүртээмжтэй байна гэдгийг шинжлэх зорилготой юм. Тиймээс уг шалгуур үзүүлэлтээр мэдээллийн хүрээ тус бүрийг бус харин тухайн вэбсайтыг бүхэлд нь хэмжсэн болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Асуулт хариултын булан. Вэбсайтад асуулт хариултын булан байгаа нь хэрэглэгч, иргэдэд өөрсдийн хүссэн асуултаа тухайн байгууллагаас тавих боломжийг олгож байдаг бөгөөд Төрийн байгууллагын вэбсайтанд асуулт үлдээн, хариултыг нь авах боломжтой булан байгаа эсэхийг шалгана.


Дурс15. Асуулт хариултын булан



Хүснэгтээс харахад төрийн байгууллагын вэбсайтад асуулт хариултын булан байгаа нь өмнөх оныхос 46.90 хувь буюу нийт 10 хувиар нэмэгдсэн. Энэ нь хэрэглэгчдэд мэдээлэл хүрэх боломж нь нэмэгдсэн, хүртээмжтэй байдал нэмэгдүүлэхэд анхаарч байгааг харуулж байна.

Хэлэлцүүлгийн булантай эсэх. Төрийн байгууллагын вэбсайтууд тодорхой нэгэн сэдвийн хүрээнд хэрэглэгчид, иргэдийн санал бодлыг сонсох, тэднийг идэвхижүүлэх үүднээс хэлэлцүүлгийг өрнүүлдэг.


Дүрс16. Хэлэлцүүлгийн булан



2010 оны судалгаанд хамрагдсан хэлэлцүүлэгтэй байсан вэбсайтын хувь 2011 онд 17.7 хувь болж даруй 62.3 хувиар огцом буурсан байна. Үүнээс үзэхэд төрийн байгууллагууд иргэдийн оролцоог хангах хэрэгсэл болох хэлэлцүүлгийн буланг ашиглахгүй байна.

Холбоотой байгууллагын холбоос/линк байгаа эсэх. Иргэдэд мэдээллийг хүртээмжтэй байлгахад чухал үүрэгтэй үзүүлэлтийн нэг бол тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, хамтран ажилладаг бусад байгууллагын холбоос вэбсайтад байршсан байдал юм. Ингэснээр төрийн байгууллагын вэбсайтад зочилж буй иргэд, хэрэглэгчид мэдээллийг нэгэн зэрэг олон талаас нь олж харах боломжтой болох юм.


Дүрс17 Холбоотой байгууллагын холбоос линк



Өнгөрсөн оны судалгаанд хамрагдсан нийт төрийн байгууллагын вэбсайтын 67,7 хувь нь уг үзүүлэлтийг хангасан байсан бол энэ онд холбоос линк агуулсан төрийн байгууллагын вэбсайт 91.7 хувь болж нэмэгдсэн байна. 2010 оныг бодвол уг үзүүлэлтийг хангах хувь ийнхүү нэмэгдсэн нь төрийн байгууллагын бусад ижил төрлийн үйлчилгээ үзүүлдэг, холбоотой харилцан ажилладаг вэбсайтыг давхар таниулж байна гэсэн үг юм.

Тогтмол асуудаг асуулт, хариулт. 2011 оны мониторингийн явцад орж ирсэн энэхүү асуулт нь тухайн байгууллагаас “тогтмол асуудаг асуултууд байгаа эсэх”-ийг мэдэхэд орших юм. Хэрэглэгчид мэдээллийг түргэн шуурхай, найдвартай хүргэхэд чиглэгдсэн энэхүү буланг төрийн байгууллагын вэбсайт дээр байх ёстой зүйлийн нэг хэмээн үзэж байна.

Дүрс18. Тогтмол асуудаг асуултын хариулт



Судалгааны дүнгээс харахад төрийн байгуулагын вэбсайтуудад тогтмол асуудаг асуулт, хариултын булантай вэбсайт нийт 21.9 хувь байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Тиймээс хэрэглэгчдийн байнга тавьдаг асуултуудад хариулт өгсөн буланг төрийн байгууллагын вэбсайтад байршуулах хэрэгтэй байна.

Хэлний сонголт. Төрийн байгууллагын вэбсайтад хэрэглэгчийн зүгээс шаардлагатай дараагийн мэдээлэл бол хэлний сонголт бөгөөд мэдээллийг монголоос бусад хэл дээр хүртэх боломжийг тухайн вэбсайт олгосон эсэхийг шалгах юм.


Дүрс19. Хэлний сонголт



Судалгааны үр дүнгээс харахад хэлний сонголттой болсон вэбсайтын үзүүлэлт 2010 оныхос 14.6 хувиар нэмэгдсэн байна.

Ийнхүү төрийн байгууллагын хүртээмжтэй байдал өмнөх оныг бодвол хэлэлцүүлгийн буланг эс тооцвол хувьд ерөнхийдөө сайжирсан байна.

Дүрс20.Мэдээллийн хүртээмжтэй байдлын үзүүлэлтүүд



Нэгтгэн дүгнэхэд 5 үзүүлэлтээс “хэлэлцүүлгийн булан” хамгийн анхаарал татахуйц байна. Учир нь энэ үзүүлэлт хамгийн бага байгаа бөгөөд хэрэглэгчдэд 1 талын урсгалтай, мэдээлэл авах боломжгүй, хүртээмжгүй болгож байгаа юм. Харин “хэлний сонголт”, “асуулт хариултын булан” зэрэг нь сайн байгаагаас гадна “холбоотой байгууллагын линк” нь хангалттай өндөр хувиар нэмэгдсэн нь иргэд хэрэглэгчдэд мэдээллийг хүртээмжтэйгээр түгээж, мэдээллийг 2 талын урсгалтай, мэдээлэл авах боломжтойг харуулж байна.

Нийт төрийн байгууллагын вэбсайтын мэдээллийн хүртээмжтэй байдлыг илэрхийлэх 5 үзүүлэлтээр авч үзэхэд дунджаар 46.3 хувиар зарим талаар хүртээмжтэй гэсэн ангилалд багтаж байна.

Хүснэгт 7. Мэдээллийн хүртээмжтэй байдлаар эхний 3 байр эзэлсэн вэбсайт

Байр	Байгууллагын нэр	Нийт бөглөгдсөн	Хувь
1	Боловсрол соёл шинжлэх ухааны яам	5	100
1	Хүүхдийн төлөө газар	5	100
1	Санхүүгийн зохицуулах хороо	5	100
2	Батлан хамгаалах яам	4	80
2	Эрдэс баялаг, эрчим хүчиний яам	4	80
2	Оюуны өмчийн газар	4	80
2	Соёл урлагийн хороо	4	80
2	Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар	4	80
2	Эрүүл мэндийн газар	4	80
2	Стандарт, хэмжил зүйн газар	4	80
2	Хүний эрхийн үндэсний комисс	4	80
2	Үндэсний статистикийн хороо	4	80
2	Улсын их хурал	4	80
3	Гадаад харилцааны яам	3	60
3	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам	3	60
3	Гадаадын хөрөнгө оруулалтын газар	3	60
3	Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар	3	60
3	Жөндэрийн тэгш байдлын үндэсний хороо	3	60
3	Нийгмийн даатгалын ерөнхий газар	3	60
3	Татварын ерөнхий газар	3	60
3	Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар	3	60
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	3	60
3	Эрчим хүчиний газар	3	60
3	Төрийн өмчийн хороо	3	60
3	Тагнуулын ерөнхий газар	3	60
3	Хил хамгаалах ерөнхий газар	3	60
3	Баян-Өлгий аймаг	3	60
3	Булган	3	60

3	Говь-Сүмбэр аймаг	3	60
3	Завхан аймаг	3	60
3	Өмнөговь аймаг	3	60
3	Төв аймаг	3	60
3	Увс аймаг	3	60
3	Улсын дээд шүүх	3	60
3	Нийслэлийн захиргааны хэргийн шүүх	3	60
3	Төрийн албаны зөвлөл	3	60
3	Сонгуулийн ерөнхий хороо	3	60
3	Монгол банк	3	60

Хамгийн олон бөглөгдсөнөөр БСШУЯ бүх үзүүлэлтийг хангаж шалгарсан.

Зураг 6.1 БСШУЯ-ны вэбсайт

Харин хамгийн муу бөглөгдсөнөөр Сүхбаатар аймаг, Үндэсний аудитын газар ямар ч хариултгүй байсан тул тодров.

Зураг 6.2 БСШУЯ-НЫ ВЭБСАЙТ

The screenshot shows the homepage of the BSUYA website. At the top, there is a banner with four video thumbnails. Below the banner, a large red button labeled 'НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ' (With Feedback) is prominently displayed. To the right of the button is a sidebar with social media links for Facebook, YouTube, Twitter, and Vimeo. Below the sidebar is a text box containing a message in Mongolian. At the bottom of the page, there are logos for various government agencies: Shingkelx Uxaanai Aakademii, Mongol Ulсыn Ikh Xural, Töriйn Hälний Zöвлöl, and Mongol Ulсыn Zasgийn Gazar.

Зураг 7. Үндэсний аудитын газрын вэбсайт

The screenshot shows the homepage of the Mongolian National Audit Office (MNAO). The header features the MNAO logo and the text 'ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР' and 'Mongolian National Audit Office'. Below the header is a navigation bar with links to 'ЭХЛЭЛ', 'БИДНИЙ ТУХАЙ', 'ЗУРГИЙН ЦМОГ', 'БҮТЭЦ', 'ТАЙЛАН', 'ХУРАЛ ЗЭВЛӨЛГӨӨН', 'ДОТООДЖУРАМ', 'ТЕНДЕР', 'АЖКЛЫН БАЙР', and 'ХОЛВОС'. The main content area is titled 'МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР'. It contains several sections: 'АЖИЛТАН ШАЛГАРУУЛЖ АВНА' (Audit Work Completed), 'МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН САНАЛ БОЛГОСНООР УЛСЫН ИХ ХУРАЛ 6 ЖИЛИЙН ХУГАЦААГАР ТОМИЛОХ БӨГӨӨД ТҮҮНИЙ НЭГ УДАА УЛИРУУЛАН ТОМИЛЖ БОЛНО.', and 'АЖИЛТАН ШАЛГАРУУЛЖ АВНА' (Audit Work Completed) for March 30, 2011, featuring an audit by the Kuwaiti Auditor General.

2.5 ВЭБСАЙТУУДЫН ХЭРЭГЛЭХЭД ХЯЛБАР БАЙДАЛ

Төрийн байгууллагын вэбсайт хэр ил тод байна вэ гэдгийг үнэлэх үндсэн таван шалгуур үзүүлэлтийн нэг нь тухайн вэбсайт хэрэглэгчдийн хувьд ашиглахад хялбар, энгийн, ойлгомжтой байх ёстой гэсэн шалгуур юм. Вэбсайт нь хэрэглэгчдэд олон алхамт үйлдэл үзүүлэхгүй, өнгө дизайнны хувьд зохицолтой, вэбсайтуудын хэрэглэгдэхүүн болох хэвлэх, хадгалах, илгээх зэрэг командуутай, холбогдох линктэй байх ёстой юм.

Хэрэглэхэд хялбар байдал (Usability) гэсэн шалгуур нь хэрэглэгчдэд тухайн вэбсайтын бүтэц, дизайн, үзэмж зэрэг нь ашиглахад хэр хялбар байгаа эсэхийг тодорхойлох юм. Үүнд вэбсайтын туслах хэрэгслүүд, үзэмж, төрх, дизайн зэрэг багтана.

Хэрэглэхэд хялбар байдлын хэмжүүрийг гаргахдаа дараахь хоёр эх сурвалжид суурилсан болно:

- Олон улсад өргөн хэрэглэгддэг “Вэбсайтын стандарт”(Weakley 2004)-д ашиглагддаг үзүүлэлт;
- Харьцуулагдахуйц байх үүднээс 2010 онд хийгдсэн “Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал” судалгаанд ашиглагдаж байсан үзүүлэлт.

Хэрэглэхэд хялбар байдалд дараахь үзүүлэлтийг хамруулсан:

1. Сайтын үсгийн фонт тохиромжтой харагдаж байна уу?
2. Сайтын цэс ойлгомжтой байна уу?
3. Сайтанд өнгөний зохицол байна уу?
4. Сайтын бүх мэдээлэл нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байна уу?
5. Сайтаас мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай програм татаж авах боломж байна уу?
6. Дурын браузер (browser)-ээс тухайн сайт руу орох боломж байна уу?
7. Сайтанд алдаа гарч байгаа тохиолдолд шийдэх арга замыг зааж өгч байна уу?
8. Сайтанд хайлтын цэс байна уу?
9. Сайтанд сайтмап (sitemap) байна уу?
10. Сайтаас хэвлэх боломж байна уу?
11. Сайтанд файлыг хадгалах боломж байна уу?
12. Сайтаас мэдээллийг бусдад илгээх боломж байна уу?

Бусад шалгуур үзүүлэлтээс ялгаатай нь хэрэглэхэд хялбар байдал нь мэдээллийг агуулгыг гэхээс илүүтэй тухайн мэдээлэл ямар хэлбэрээр хүрч байна гэдгийг шинжлэх зорилготой юм. Тиймээс уг шалгуур үзүүлэлтээр мэдээллийн хүрээ тус бүрийг бус харин тухайн вэбсайтыг бүхэлд нь хэмжсэн.

Эдгээр үзүүлэлт тус бүрийг ямар түвшинд хангаж байгаагаас хамааран тухайн вэбсайтыг дараахь дөрвөн ангиллаар ангилах боломжтой байна.

1. Хэрэглэхэд бүрэн хялбар(81-100 хувь)
2. Хэрэглэхэд боломжтой (61-80 хувь)
3. Хэрэглэхэд төвөгтэй (41-60 хувь)
4. Хэрэглэхэд маш төвөгтэй (0-40 хувь)

Сайтын үсгийн фонт тохиромжтой харагдаж байна уу. Сайтын үсгийн фонтны хувьд Arial, Web Tahoma байдаг бөгөөд гарчиг 14-16, гол мэдээлэл 10-12 хэмжээтэй байх ба

хамгийн гол нь хэрэглэгчдэд харагдахуйц байна (Weakley 2004). Хэдийгээр интернэтийн орчинд тухайн вэбсайтыг томруулж, жижигрүүлэх арга байдаг ч гэсэн хамгийн анх вэбсайт руу ороход хэрэглэгчдэд тохиромжтой харагдахуйц фонтны хэмжээтэй байх ёстой юм.

[Дурс21 Сайтын үсгийн фонт тохиромжтой харагдахуйц байна уу?](#)



Нийт судалгаанд хамрагдсан 96 вэбсайтын 93.8 хувь нь уг үзүүлэлтийг хангасан байна. Энэ нь төрийн байгуулагын вэбсайтууд хэрэглэгчдэд уншигдахуйц байдлаараа шаардлагыг бүрэн хангаж байгааг харуулж байна.

Сайтын цэс (text) ойлгомжтой байна уу. Сайтын цэсийг хэрэглэгч мэдээллийг хялбараар, олж харахад ойлгомжтой байдлаар ангилагдсан байгаа эсэхээр нь дүгнэсэн юм.

[Дурс22 Сайтын цэс ойлгомжтой байна уу?](#)




Вэбсайтуудын 82.3 хувийнх нь цэс ойлгомжтой байдлаар ангилагдсан байна. Харин үлдсэн хэсгийнх нь вэбсайтуудын цэс нь доош гүйхгүй, цэснээс хэрэгцээтэй мэдээллийн гарчиг бүлгээрээ гарч ирэхгүй гэх мэт асуудалтай байсан.

Сайтанд өнгөний зохицол байна уу. Сайтад өнгөний дагнаас зохицол бүхий 2-3 өнгө байдаг ба мэдээлэл хооронд өнгөөр ялгагдаж байгаа эсэхийг дараахь үзүүлэлтээр голлон авч үзэв (Weakley 2004).

- Мэдээллийн түвшингээр ялгаатай
- Гарчиг, гол мэдээлэл ялгаатай
- Үндсэн мэдээ, дэд мэдээ ялгаатай

[Дурс23 Сайтанд өнгөний зохицол байна уу?](#)



Төрийн байгууллагын вэбсайтын өнгө үзэмж нь 92.7 хувьтай байгаа нь хэрэглэгч иргэдэд ойлгомжтой, хэрэглэхэд хялбар болсныг харуулж байгаа юм.

Сайтын бүх мэдээлэл нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байна уу. Аль нэг улс орны вэбсайтад тухайн орны хэлээс гадна олон улс даяар хэрэглэгддэг өөр нэг хэлний төрлийн сонголт байдаг нь тухайн вэбсайтыг хэрэглээг нэмэгдүүлдэг, олон улсын хэрэглэгчдэд хэрэглэхэд хялбар болгодог.


[Дурс24 Сайтын бүх мэдээлэл нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байна уу?](#)



Вэбсайтад англи, монгол хэлний сонголт байдаг хэдий ч энэ нь жинхэнэ утгаараа хэрэгжихгүй байгааг харуулж байна. Нийт судалгаанд хамрагдсан вэбсайтын 24 хувь нь бүх мэдээллээ сонгосон хэл рүү хөрвүүлж байна.

Сайтаас мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай програм татах авах боломж байна уу. Сайтаас мэдээлэл унших үед зарим нэг нэмэлт программыг ашиглах шаардлага байдаг бөгөөд тус программыг татах холбоос байгаа эсэхийг шалгана.


[Дурс25 Сайтаас мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай програм татах авах боломж байна уу?](#)



Вэбсайтын 21.9 хувь нь шаардлагатай програм татах авах боломжтой байна. Мэдээллийг уншихад хялбар болгож өгдөг нэмэлт программыг татах боломж багатай байгаа нь вэбсайтыг хэрэглэхэд төвөгтэй байгааг харуулж байна.

Дурын браузер (browser)-ээс тухайн сайт руу орох боломж байна уу. Вэбсайтуудтай ажиллах хэрэглэгч өөрсдийн хэрэглэж сурсан браузер (Internet Explorer, Mozilla, Google Chrome г.м.) –ийг ашигладаг. Зарим вэбсайт сонгосон нэг л төрлийн браузерээсээ нээгддэг бөгөөд энэ нь хэрэглэгчдэд төвөгтэй байдаг. Судалгаагаар тухайн вебсайт дурын браузер (browser)-ээс нээгддэг эсэхийг нь шалгах юм.

Дурс26 Дурын браузер тухайн сайт руу орох боломж байна уу?



Төрийн байгууллагын вэбсайтуудыг дурын ямар ч браузерээс нээж ажиллах боломжтой байгаа нь хэрэглэгчдэд хэрэглэхэд хялбар байгааг харуулж байна.

Сайтанд алдаа гарч байгаа тохиолдолд шийдэх арга замыг зааж өгч байна уу. Вэбсайтыг хэрэглэх явцад алдаа гарлаа гэхэд хэрэглэгчдэд тус саадыг давах арга замыг зааж өгсөн, ямар учраас алдаа гарсан талаар тайлбар гарч ирэх ёстай байдаг (Weakley 2004). Энэ нь хэрэглэгчдэд вэбсайтыг хэрэглэхэд хялбар болгоно.


Дурс27 Сайтанд алдаа гарч байгаа тохиолдолд шийдэх арга замыг зааж өгч байна уу?



Вэбсайтанд алдаа гаражад алдааг засах аргыг хэр заадаг вэ? гэдэгт шинжилгээ хийж үзэхэд судалгаанд хамрагдсан вэбсайтуудын 25% нь ямар нэг алдаа зааж байв. Үүнээс 8 нь буюу 33.3% нь хэрэглэгчдэд ямар нэг зааварчилгаа өгсөн байсан бол үлдсэн 66.7% нь ямар нэг тайлбар, зааварчилгаа огт өгөөгүй байна.

Сайтанд хайлтын цэс байна уу. Вэбсайтад хайлтын цэс байх нь хэрэгчдэд хэрэгтэй мэдээллийг түргэн хугацаанд хайж олох, холбоотой мэдээллийг хялбар аргаар олж авах боломж бурдүүлдэг. Вэбсайт бүрт хайлтын цэс байх ёстай бөгөөд хайлтын цэс байгаа эсэхийг энэ үзүүлэлтээр шалгана.


Дурс28 Хайлтын цэстэй вэбсайтуудын хувь



Хайлтын цэс 2011 онд 77.1 хувьтай, харьцангуй өндөр үзүүлэлттэй гарч байгаа боловч өмнөх оныхтой харьцуулахад ялимгүй бага хувьтай байлаа.

Сайтанд сайтмап (sitemap) байна уу. Сайтмап гэдэг нь сайтын бүтэц зохион байгуулалтыг бүтнээр нь харах боломжтой дүрслэл байна. Түүгээр сайтыг хамгийн хялбараар ерөнхийд нь харж ойлгох боломжтой болдог.


Дурс39 Сайтанд сайтмап байна уу?



Вэбсайтын алхмуудыг хялбарчлах сайтмап нийт вэбсайтын 51 хувьд нь байсан байна.

Сайтаас хэвлэх боломж байна уу. Аливаа вэбсайтад мэдээллийг шууд хэвлэх команд байдаг нь хэрэглэгчийн хэрэглээг хялбарчилж өгдөг. Энэ нь төрийн байгууллагын вэбсайтаас сонгосон мэдээллийг хэвлэх шигтгээ зураг (icon) эсвэл команд байгаа эсэх, мэдээллийг хэвлэх боломжтой эсэхийг шалгана.

Дурс 30 Сайтаас хэвлэх боломж байна уу?



Вэбсайтаас нь ямар нэг мэдээлэл хэвлэх боломж нийт байгууллагын 70.8 хувьд нь байжээ.

Сайтанд байгаа файлыг хадгалах боломж байна уу. Аль нэг вэбсайтад мэдээллийг хадгалах боломж олгосон команд байх нь хэрэглэгчийн хэрэглээг хялбарчилж өгдөг. Вэбсайтаас сонгосон мэдээллийг хадгалах шигтгээ зураг (icon) эсвэл команд байгаа эсэх, мөн мэдээллийг хадгалах боломжтой эсэхийг энэ үзүүлэлтээр харуулав.

Дурс31 Сайтанд файлыг хадгалах боломж байна уу?



Төрийн байгууллагын вэбсайтуудаас хүссэн мэдээллээ татаж авах, хадгалах боломж 66.7 хувьтай байгаа нь хэрэглэгчдэд хэрэглэхэд хялбар байгааг харуулж байна.


Вэбсайтаас ямар нэгэн мэдээллийг илгээх боломж нийт вэбсайтын 57.3 хувьд нь байв.

Дурс32 Сайтаас мэдээллийг бусдад илгээх боломж байна уу?



Нэгтгэн дүгнэхэд 12 үзүүлэлтээс вэбсайтаас мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай программ татаж авах боломж байна уу? гэсэн үзүүлэлт бусдаасаа хамгийн доогуур байв. Харин сайтын хайлтын цэс, өнгөний зохицол, үсгийн фонт тохиромжтой зэрэг үзүүлэлт ерөнхийдөө хангалттай байна.

Дурс33 Хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлтүүд



Нийт төрийн байгууллагын вэбсайтыг мэдээллийн хүртээмжтэй байдлыг илэрхийлэх 12 үзүүлэлтээр авч үзэхэд дунджаар 64.07 хувьтай байна. Ингэснээр төрийн байгууллагын вэбсайтууд хэрэглэхэд хялбар байдлаараа боломжийн гэсэн ангилалд багтаж байна.

Хүснэгт8 Вэбсайтыг хэрэглэхэд хялбар байдлын шалгуураар эхний 3 байр эзэлсэн вэбсайтууд

Байр	Байгууллагын нэр	Нийт бөглөгдсөн	Хувь
------	------------------	-----------------	------

1	Батлан хамгаалах яам	10	100.00
2	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	11	91.67
2	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	11	91.67
2	Говь-Алтай аймаг	11	91.67
3	Архивын ерөнхий газар	10	90.91
3	Мал эмнэлэг, үргжлийн газар	10	90.91
3	Төмөр замын газар	10	90.91
3	Усны газар	10	90.91
3	Онцгой байдлын ерөнхий газар	10	90.91
3	Улсын дээд шүүх	10	90.91
3	Үндэсний статистикийн хороо	10	90.91

Хамгийн хэрэглэхэд хялбар вэбсайтаар Батлан хамгаалахын яам шалгарч байгаа бөгөөд хамгийн бага буюу 1 хариулт өгснөөрөө Биеийн тамир спортын газар шалгарсан байна.

Зураг 8. Батлан хамгаалах яамны вэбсайт

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ
МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Нүүр хуудас Вэбийн бүтэц Холбоо барих

Google Custom Search

Батлан хамгаалах бодлого Батлан хамгаалах яам Гадаад хамтын ажиллагаа Орон нутгийн цэргийн штаб Мэдээллийн төв Цэргийн алба Аявлигын эсрэг Гишүүдийн булан E-mail

Нүүр хуудас > Мэдээ, мэдээлэл

Батлан хамгаалах яамны мэдээлэл

Батлан хамгаалахын сайд Л.Болдыг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнав

2012 оны 01 сарын 02 | enkhtuvshin

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зөвсигт хүчиний ерөнхий командлагч Ц.Элбэгдорж Батлан хамгаалах асуудал эрхэлэн төрийн захиргааны төв байгууллага Цэргийн хөргүй буда захирэн шийтгэгч яам буюу инөөгийн Батлан хамгаалах яам байгуулласан 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын батлан хамгаалах салбарын хөгжил давшил, Зөвсигт хүчиний шинчлэлд унтай хувь нэмэр оруулсан УИХ, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Л.Болдыг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасан юм.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ

[Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт](#)

САНАЛ АСУУЛГА

Манай вэбийг үнэлнэ үү
 Сайн
 Дунд
 Муу
[Санал](#) [Үр дүн](#)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗӨВСИГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ КОМАНДЛАГЧ

Хэрэглэгчдэд хэрэглэхэд хялбар гэж тооцогдож буй энэхүү вэбсайтад өнгө, үсгийн фонтны зохицол, хэвлэх, илгээх боломж мөн хайлтын цэс байгааг харж болно.

Зураг 9. Багануур дүүргийн шүүх

The screenshot shows the homepage of the Baganuur Court (БАГАНУУР ДҮҮРГИЙН ШҮҮХ). At the top, there are two seals: the left one is blue with a scale and a sword, and the right one is orange with an eagle. The title "БАГАНУУР ДҮҮРГИЙН ШҮҮХ" is prominently displayed in the center. Below the title, there are two navigation links: "ЧИЙСЛЭЛИЙН ШҮҮХ" and "Танилцуулга". A sidebar on the left lists "Үндсэн цэс" items: Нуур хувдас, Танилцуулга, Бүтцэ, Эзжикон, Байгуулалт, Мэдээ мэдээлэл, Мэдээлэл лавлагаа, Ес зүйн дүрэм. Another sidebar on the left lists "ШҮҮХ ХУРАЛДАНЫ ЗАР" items: Эрүүгийн хэргийн шүүх хуралданы зар, Иргэний хэргийн шүүх хуралданы зар. On the right side, there is a section titled "ШИЙДВЭР, ШИЙТГЭХ ТОГТООЛ" with two sub-links: Шийтгэх тогтоол and Шийдвэр. Below this, there is a question: "Шүүх, шүүхийн байгууллагатай холбоотой мэдээллийг хаанаас авдаг вэ?" followed by a list of media sources: Телевиз, FM, Radio, Сонин сэтгүүл, Интернет, Хэн нэгнээс, and Бусад. At the bottom right, there are two buttons: "Санал" and "Үр дүн".


Уг байгууллагын вэбсайтны үсгийн фонд алдаатай, хэрэглэгчдэд хэрэглэгдэх хэвлэх, хадгалах, илгээх боломж байхгүй мөн хайлтын цэсгүй байгааг харж болно.

БҮЛЭГ 3. МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ

Вэбсайтын ил тод байдлыг хэмжих үндсэн таван шалгуураар монголын нийт 100 төрийн байгуулагын вэбсайт (4 вэбсайт тодорхой шалтгаанаар шинжилгээ хийгдэх боломжгүй болсноор хасагдаж нийтдээ 96 вэбсайт дээр шинжилгээ хийгдсэн юм) хэр ил тод байгаад бүхэлд нь үнэлэхэд төрийн байгууллагын вэбсайтууд бүхэлдээ 40 хувь буюу ил тод бус, хаалттай гэсэн үнэлгээ авч байна. Энэ нь ил тод байдлыг үнэлэх үнэлгээний хамгийн доод шат буюу муу гэсэн ангилалд хамаарах дүн юм.

Өнгөрсөн оны судалгаагаар вэбсайтын ил тод байдлыг нарийвчлан үнэлээгүй тул тоон үзүүлэлт ашиглан ил тод байдал нэмэгдсэн эсвэл буурсан гэж дүгнэх боломжгүй юм. Гэсэн ч хоёр удаагийн судалгаагаар дараалан илэрсэн гол үр дүнг харьцуулахад шалгуур үзүүлэлтийг хангасан байдал хэвэндээ, төдийлөн өөрчлөгдөөгүй байв. 2011 оны мониторингод хамрагдсан вэбсайт өмнөх оны түүврээсээ 25 хувиар их байгаа ч энэ нь судалгааны үр дунд нөлөөлөхүйц өөрчлөлт оруулсангүй. Судалгааны нэгтгэсэн дүнг дараах хүснэгтээс нарийвчлан харж болно.

Дурс 34. Шалгуур бүрийн дүн



Вэбсайтыг ашиглахад хялбар байдал буюу вэбсайтын техникийн талын үзүүлэлт 64 хувь буюу хамгийн өндөр дүнтэй байгаа бол мэдээллийн найдвартай байдал болох вэбсайт дахь мэдээллийн эх сурвалж, баттай мэдээлэл нь 6.9 хувь буюу хамгийн бага дүнтэй байна. Энэ нь хэдийгээр вэбсайт техникийн хувьд өсөн дэвжиж байгаа боловч доторх мэдээллийн чанар, найдвартай байдал дээр анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Ингээд хэсэг бүр дээр гарсан дүгнэлтийг танилцуулж байна.

1. Мэдээллийн холбогдолтой байдал – судалгааны явцад өнгөрсөн жилтэй харьцуулан шинжилгээг хийсэн бөгөөд 2011 онд гарсан үр дүн өнгөрсөн оныхос төдийлөн өөрчлөгдөөгүй байлаа. Гэвч өнгөрсөн онтой харьцуулахад байгууллагын цахим шуудангийн хаяг, олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр, албан тушаалын талаарх мэдээлэл тавигдах нь сайжирсан байна. Уг үзүүлэлт бүхэлдээ 50 хувьтай биелэгджээ.
2. Мэдээллийн найдвартай байдал – судалгааны дүнгийн хувьд хамгийн муу буюу 6 хувьтай гарсан энэхүү хэсгийг дүгнэн хэлэхэд вэбсайтын мэдээлэл хэрэглэгч,

иргэдэд хүрэхдээ ямар нэг эх сурвалжгүй буюу найдваргүй байдлаар хүрч байна. Ялангуяа төсөв, санхүүгийн мэдээлэл уг үзүүлэлтээр хангалтгүй гарч байна.

3. Мэдээллийн цаг үеийн байдал – дэд гурван үзүүлэлтээр уг шалгуурыг хэмжсэн бөгөөд вэбсайтууд бүхэлдээ дунджаар 35 хувийн үзүүлэлттэй гарсан. Энэ нь вэбсайтууд дахь 143 дугаар тогтоолд холбогдолтой мэдээлэл хоцрогдсон мөн тогтмол шинэчлэгдэггүй болохыг харуулж байна.
4. Мэдээллийн хүртээмжтэй байдал – дөрвөн үзүүлэлтээр хэмжсэн. Судалгааны дүнд төрийн байгууллагын вэбсайтууд уг үзүүлэлтээр 46 хувьтай байгаа ба вэбсайт нь зарим талаар л хэрэглэгчдэд хүртээмжтэй байна. Хэдийгээр 2010 оны дүнтэй харьцуулахад дөрвөөс гурван үзүүлэлт нь сайжирсан, эерэг үзүүлэлттэй байгаа боловч мэдээлэл зөвхөн нэг талын урсгалтай байгаа бөгөөд төрийн байгууллагууд эргээд иргэдийн оролцоог хангах, тэднийг сонсох тал дээр дутагдалтай байна..
5. Вэбсайтыг хэрэглэхэд хялбар байдал – судалгааны дүнгээр хамгийн өндөр буюу 64 хувьтай гарсан хэсэг юм. Өнгөрсөн онтой харьцуулахад онцгой өөрчлөлт гараагүй үзүүлэлт хэвээр хадгалагдаж байв. Төрийн байгууллагын вэбсайт хэрэглэхэд хялбар байгаа нь техникийн талаараа бусад үзүүлэлтээс давуу байгааг харуулж байна.

Монголын төрийн байгууллагын вэбсайт нь 143-р тогтоолд хамаарах мэдээллийг зарим талаар хангалттай хэмжээнд агуулсан байгаа боловч эдгээр мэдээлэл нь ихэнхидээ найдваргүй, хоцрогдсон, тогтмол шинэчлэгдэггүй байна. Мөн вэбсайт нь нэг талын урсгал давамгайлсан, хэрэглэгчдийг мэдээлэл авах боломжоор хангасан боловч тэдний оролцоог хангах тал дээр дутагдалтай байна. Энэ нь 2010 оны судалгааны “манай төрийн байгууллагын цахим хуудсууд өдийг хүртэл байгууллагын сурталчилгааны самбар төдий үүрэг гүйцэтгэж байна” гэсэн дүгнэлт өнөөдөр хүчинтэй байгааг харуулж байгаа юм.

Өнгөрсөн оны судалгааны үр дүнгээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн цахим засаглалын хөгжлийн дөрвөн үе шатны дагуу авч үзэхэд манай орны төрийн байгууллагын вэбсайтууд хөгжлийн эхний шатанд буюу мэдээлэл түгээх шатанд үйл ажиллагаагаа явуулж байгаа нь илэрсэн. Энэ оны судалгаанаас харахад вэбсайтууд бүхэлдээ хөгжлийн нэг шат ахисан эсэхийг харахад нөхцөл байдал дээрдээгүй, хэвэндээ болох нь илэрсэн юм. Эцэст нь дүгнэхэд төрийн байгууллагын вэбсайтууд нь техникийн энгийн шалгуурыг л хангаж байгаа ба ашиглахад боломжийн байгаа боловч бүхэлдээ ил тод бус, хаалттай байна.

БҮЛЭГ 4. САНАЛ ЗӨВЛӨМЖ

2011 оны судалгаанд хамрагдсан бүх байгууллага өөрийн гэсэн албан ёсны вэбсайттай болсон, түүнийгээ тодорхой түвшинд ашиглаж байгаа нь төрийн байгууллагын вэбсайтыг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах эхний суурь тавигдсан болохыг харуулж байна.

Гэсэн ч уг судалгааны дүнгээс харахад Монголын төрийн байгууллагын вэбсайтууд цахим засаглалын хөгжлийн дөрвөн үе шатны хувьд эхний буюу хамгийн доод шатанд явж байна. Үүнд нөлөөлж буй гол хүчин зүйлс бол 143 дугаар тогтоол дахь мэдээлэл бүрэн тавигдахгүй байгаа, тавигдсан ч оновчтой цаг хугацаанд, эх сурвалжтайгаар тавигдахгүй байгаа, мөн иргэдийн оролцоог хангасан байдал хангалтгүй байгаа явдал юм. Тиймээс эдгээр сул талыг сайжруулах хүрээнд хэд хэдэн санал зөвлөмжийг боловсруулсан юм. Одоо эдгээрийг тус бүрээр нь нарийвчлан авч үзье.

Байгууллагын дүрэм журам, төлөвлөгөөг боловсронгуй болгох чиглэлээр:

- Вэбсайтыг ажиллуулах журам боловсруулах түүнийг мөрдөх.** Мэдээллийн ил тод байдал ба мэдээллийн эрхийн тухай хууль 2011 оны 6 сарын 16-нд батлагдсан нь төрийн зүгээс уг асуудалд анхаарал хандуулж буйг харуулж байгаа ба төрийн байгууллагын вэбсайтыг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн юм. Тиймээс уг хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс төрийн байгууллага бүр өөрийн вэбсайтыг ажиллуулах журам боловсруулах, түүнийгээ мөрдөх шаардлагатай. Тухайлбал өнөөгийн байдлаар бидэнд мэдэгдэж байгаагаар Төрийн албаны зөвлөл, Шүүх байгууллага, Монгол банк зэрэг байгууллагууд вэбсайт ажиллуулах журамтай болсон байна. Энэ жишгийг бусад байгууллага мөрдөх боломжтой юм.
- Төлөвлөгөөтэй болох.** Өнөөдөр төрийн байгууллагын түвшинд мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр өрөнхий зорилгууд байгаа боловч эдгээрийг өдөр тутмын үйл ажиллагаатай уялдуулсан тодорхой томъёолол дутагдалтай байна. Тиймээс байгууллага бүр өөрсдийн вэбсайтыг сайжруулах, вэбсайт ажиллуулах үйл ажиллагаануудыг улирлын болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж байх хэрэгтэй. Ингэхдээ уг төлөвлөгөөг биелүүлэх хугацаа, холбогдох албан тушаалууд, хэрэгжүүлэх албан тушаалууд зэргийг тодорхойлж ажил үүргийн хуваарийг тодорхой болгох боломжтой.
- Ажил үүргийн хуваарийг тодорхой болгох.** Энэ хүрээнд хэрэгжүүлж болох нэг арга зам бол төрийн албан хаагчдын үйл ажиллагааг дүгнэх үр дүнгийн гэрээнд тухайн албан хаагч өөрийн эрхэлж буй албан тушаалтай холбогдох ямар төрлийн мэдээллийг вэбсайтанд тавих шаардлагатай талаар заасан байх, мөн эдгээр мэдээллийг тогтмол бэлдэж, гаргаж өгөх асуудлыг тусгах явдал юм. Уг арга замыг хэрэгжүүлснээр дээрх хуулийн 24.2 дугаар зүйлд дурдсан “төсвийн өрөнхийлөн захирагч, өрөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээнд мэдээллийн ил тод

байдлыг хангах талаар тусгаж, үнэлгээний гол шалгуурын нэг болгон дүгнэнэ” гэсэн заалтыг давхар биелүүлнэ гэсэн үг юм.

4. **Хууль, тогтоолд заасан мэдээллийг вэбсайтад бүрэн гүйцэд байрлуулах.** Мэдээллийн ил тод байдал ба мэдээллийн эрхийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлэг буюу олон нийтэд ил тод болгохыг хориглох мэдээлэл, мөн тухайн байгууллага өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй мэдээллийн жагсаалтыг гаргах. Үүнтэй зэрэгцэн уг байгууллагаас вэбсайтад тавигдсан байх шаардлагатай, байнга шинэчлэгдэж байх, ач холбогдол өндөртэй мэдээллийн хүрээ, төрлийн талаарх жагсаалтыг гаргах. Эдгээр жагсаалтыг байгууллага өөрийн вэбсайт ажиллуулах журамд оруулах боломжтой юм.

Иргэд, хэрэглэгчдийн оролцоог хангах чиглэлээр:

1. **Хэрэглэгчид вэбсайтаар дамжуулан мэдээлэл авах, хүсэх үйл явцыг тодорхой болгох.** Мэдээллийн ил тод байдал ба мэдээллийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлд иргэд төрийн байгууллагаас цахим хэлбэрээр мэдээлэл авах эрхтэй болохыг заасан байдаг. Тиймээс иргэд ямар төрлийн мэдээллийг тухайн төрийн байгууллагаас авч болох, аваадаа ямар журам, процедурыг мөрдөх шаардлагатай болохыг вэбсайтад ойлгомжтой, ил, харагдахуйц байдлаар тавьсан байх шаардлагатай.
2. **Вэбсайтад иргэдийн оролцоог хангасан сувгуудыг бий болгох.** Үүнд вэбсайтад асуулт хариултын булантай болох, форумтай болох, мөн иргэдийн портал системтэй болох боломжтой. Портал системтэй болно гэдэг нь их хэмжээний мэдээлэл, үйлчилгээ зэргийг хэрэглэгчдэд ашигтай, ойлгомжтой байдлаар нэгтгэсэн байх алхам болох юм. Ийнхүү техникийн хувьд суваг нээлттэй боллоо гэхэд найдвартай, цаг үеийн мэдээлэл өгөх үүднээс хариуцсан мэргэжилтнүүдтэй холбогдох боломжкоор хангах нь чухал.

Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр:

Төрөөс төрийн албан хаагчдын вэбсайтаар дамжуулан иргэдтэй харилцах, мэдээллийн ил тод байдлыг хангах, эдгээрийн ач холбогдлын талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, төрийн албан хаагчдыг идэвхижүүлэх тал дээр хангалтгүй ажиллаж байгаа нь төрийн байгууллагын вэбсайт нэлэнхүйдээ ил тод бус гэсэн мониторингийн дүнгээс ажиглагдсан юм. Тиймээс төрийн байгууллагын вэбсайтын ил тод байдлыг сайжруулах зорилгод хүрэхийн тулд байгууллагад шаардлагатай сургалтыг дараахь гурван төвшинд явуулах шаардлагатай.

1. **Төрийн албан хаагчдын дунд сургалт зохион байгуулах.** Төрийн байгууллагын анхан шатны нэгж болгоны нэгээс доошгүй мэргэжилтнийг иргэдтэй онлайн харилцаа үүсгэх сургалт зохион байгуулах. Уг сургалтын үндсэн зорилго нь хэрэглэгчийн зүгээс ирүүлж байгаа саналыг хүлээж авах, тэдэнд тогтмол хариу өгч хоёр талын харилцаан үйлдлийг сайжруулж иргэдийн онлайн оролцоог дэмжих юм. Энэ сургалтын агуулга нь техникийн буюу мэдээллийг вэбсайтанд оруулах, мөн

иргэдийн онлайн оролцооны сайн туршлага, бусад орны жишээн дээр суурилсан байх боломжтой.

2. **Вэбсайт хариуцсан мэргэжилтнийг сургах.** Мэдээллийн ил тод байдлыг хангахад мэдээллийн технологийн ба төрийн байгууллагын менежментийн чадавхи аль аль нь чухал байдаг учраас төрийн байгууллагын вэбсайтыг ажиллуулж байгаа мэргэжилтнийг сургах сургалтыг явуулах хэрэгтэй. Уг сургалтаар мэргэжилтэн нь ямар мэдээллийг ажилтнуудаас хүлээж авах, хүлээж аваадаа уг мэдээллийн эх сурвалж, он сар өдөр зэрэг нь тодорхой байгаа эсэхийг шалгах, байгууллагынхаа вэбсайт ажиллуулах журмын талаар бүрэн ойлголттой болох зэрэг чадваруудыг мэргэжилтэнд олгох боломжтой юм. Энэ нь тухайн байгууллага болон вэбсайт хариуцсан мэргэжилтнүүд хоорондоо уялдаатай ажиллах боломжийг хангах юм.
3. **Удирдлагуудын дунд нөлөөллийн ажил явуулах.** Төрийн байгууллагын салбар/хэлтэс удирдах албан тушаалтнуудыг хамарсан сургалтаар дамжуулан удирдлагуудын зүгээс энэхүү асуудалд илүү анхаарал хандуулахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг явуулах үргэлжлүүлээн явуулах хэрэгтэй. Уг нөлөөллийн ажилд мониторингийн үр дүнг мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газраас явуулдаг 143 дугаар тогтоолын хэрэгжилтийн улирал тутмын үнэлгээг тус тус ашиглах хэрэгтэй.

Төрийн байгууллагын вэбсайтын ил тод байдлыг үнэлэх хяналт, шинжилгээ үнэлгээг боловсронгуй болгох чиглэлээр:

1. **Хэрэглэгчдийн хэрэгцээг хангасан байдлын талаарх шалгуур үзүүлэлтийг нэмэх.** Төрийн байгууллагын вэбсайт дахь мэдээллийн ил тод байдлыг хангахад хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага ямар байгаа талаар мэдээлэл, мэдлэгтэй болох шаардлагатай. Ингэснээр вэбсайтын мониторингийн арга зүйд хэрэглэгчийн хэрэгцээнд тулгуурласан байдал хэмээх үндсэн шалгуур үзүүлэлт нэмэгдэх ба уг үзүүлэлтийн үр дүнг иргэдийн оролцоог хангаж буй байдлын хэрэгжилтийг үнэлэхэд ашиглах боломжтой болно.
2. **Мониторингийг тогтмолжуулах, бусад хяналт шинжилгээний ажлуудтай уялдуулах.** Төрийн байгууллагын ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн 143-р тогтоолын хүрээнд вэбсайтанд тавигдаж байгаа мэдээллийт тогтмол хөндлөнгийн мониторинг хийх ажлыг жил бүр үргэлжлүүлэх хэрэгтэй. Уг хөндлөнгийн мониторингийг төрийн иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагууд хэрэгжүүлж үр дүнг төрийн байгууллага болон олон нийтэд тархаах, сурталчлах нь чухал ач холбогдолтой юм. Мөн хөндлөнгийн мониторингийн үр дүн болон төрийн байгууллагаас, тодруулбал Засгийн газрын хэрэг эрхлэх газраас хийгдэг хяналт шинжилгээний үр дүнг солилцон ашиглах, цуглуулсан мэдээллийг хуваалцах зэргээр хоорондын уялдааг сайжруулах хэрэгтэй юм.
3. **Байгууллагын дотооддоо хяналт шинжилгээг хийдэг болох.** Түүнчлэн төрийн байгууллагууд дотооддоо вэбсайтанд тавигдах мэдээлэл, түүний чанарт тавих хяналтын механизмыг бий болгох, сайжруулах нь чухал. Ингэснээр нэгдүгээрт зөвхөн гаднаас хянуулах бус байгууллага өөрөө илүү ойроос, чанарын талаас нь вэбсайтын мэдээллийн ил тод байдлын талаарх журмынхаа хэрэгжилтийг үнэлэх

болно. Мөн дараа дараагийн мониторингоор төрийн байгууллагын вэбсайтын ил тод байдлыг хангах дотоод механизм, хяналт бий болсон эсэхийг үнэлж дүгнэх боломж бүрдэнэ.

Эдгээр санал зөвлөмжийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага дангаараа бус харин өөр хоорондын сайн туршлага, нөөц бололцоо, чадавхийг тогтмол хуваалцаж, хамтран ажиллах нь илүү үр дүнтэй юм. Төрийн байгууллагын энэхүү уялдаа холбоог бий болгох, мэдээлэл солилцох санаачилга, зохицуулалтыг үйл ажиллагааны хувьд шууд хамааралтай гэдэг утгаараа Мэдээлэл, харилцаа, шуудан холбоо, технологийн газар болон Засгийн газрын хэрэг эрхлэх газраас тус тус гаргаж, тэргүүлэх хэрэгтэй болохыг онцлон тэмдэглэж байна.

Ашигласан материал

Alanezi, Mohammed Ateeq, Ahmed Kamil, and Shuib Basri. "A proposed instrument dimensions for measuring e-government service quality." *International Journal of u- and e- Service Science and Technology* 3, no. 4 (2010): 1-18.

Drew, C. H, and T. L Nyerges. "Transparency of environmental decision making: a case study of soil cleanup inside the Hanford 100 area." *Journal of Risk Research* 7, no. 1 (2004): 33-71.

Harris, Robert. "Evaluating Internet Research Sources." *Virtual Salt*, 2010.

OECD. "Promoting Good Governance." 2011. http://www.gdrc.org/u-gov/doc-oecd_ggov.html (accessed 11 29, 2011).

UNESCAP. "What is Good Governance." *United Nations ESCAP*. 2011.

<http://www.unescap.org/pdd/prs/ProjectActivities/Ongoing/gg/governance.asp> (accessed 11 27, 2011).

Weakley, Russ. "Web standards checklist." *Max Design*. August 13, 2004.

<http://www.maxdesign.com.au/articles/checklist/> (accessed 11 28, 2011).

Монгол Улсын Хууль. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль. 2011 оны 6 сарын 16.

МУЗГ. "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт." Засгийн газрын 2009 оны 143 дугаар тортолын хавсралт, 2009.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Авлигатай Тэмцэх Газар. "Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал вэб орчинд хийсэн мониторингийн тайлан 2010." Улаанбаатар, 2010.

ХАВСРАЛТ 1. СУДАЛГААНЫ АНКЕТ

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ” ВЭБ ОРЧИНД ХИЙХ МОНИТОРИНГ-2011 (Судалгааны анкет)

1. Судлаачийн нэр:.....
2. Анкетын дугаар:.....
3. Байгууллагын нэр:.....
4. Вэбсайтын хаяг:.....
5. Судлаач тухайн вэбсайт дахь хандалтын тэмдэглэгээ:

№	Он	Сар	Өдөр	Цаг	Минут
1	I дэхь				
2	II дахь				
3	III дахь				
4	IV дахь				

6. Тухайн байгууллагын цахим хаягаар шууд хандахад нээгдсэн үү?
(Байгууллагын цахим хуудсанд хандсан хамгийн сүүлийн үр дүнг бичнэ.)
 1. Шууд нээгдсэн (9-р асуулт руу шилжинэ үү)
 2. Цахим хуудас засвартай гэсэн мэдээлэл гарсан (Судалгааг зогсоох)
 3. Цахим хуудас нээгдээгүй(7-р асуулт руу шилжинэ үү)
7. Цахим хуудас нээгдээгүй бол www.google.mn -ээс хайлт хийнэ үү
 1. Олдсон цахим хуудас нээгдсэн. (9-р асуулт руу шилжинэ үү)
 2. Олдоогүй (8-р асуулт руу шилжинэ үү)
 3. Олдсон боловч ажилдаггүй цахим хуудас байсан (судалгааг зогсоох)
8. Олдоогүй бол Засгийн газрын www.pmis.gov.mn цахим хуудасны холбоосоор орж шалгана уу?.
 1. Олдсон цахим хуудас нээгдсэн. (9-р асуулт руу шилжинэ үү)
 2. Олдсон боловч цахим хуудас ажиллахгүй байсан (Судалгааг зогсоох)
 3. www.pmis.gov.mn-ий холбоосонд байгаагүй (Судалгааг зогсоох)
9. Цахим хуудсанд хандсан үйлчлүүлэгчдийг тоог харах боломж байна уу?
 1. Тийм
 2. Үгүй (11-р асуулт руу шилжинэ үү)
10. Цахим хуудсанд хандсан үйлчлүүлэгчдийн тоо?

№		Тоо	Харах боломжгүй
1	Нийт зочилсон хүн		999
2	Жилд зорчсон хүн		999
3	Сард зорчсон хүн		999
4	Өдөрт зорчсон хүн		999

11. Цахим хуудсанд сэтгэгдэл оруулах боломжтой юу?
 1. Тийм
 2. Үгүй

1. Мэдээллийн ХОЛБОГДЛОЙ Байдал

12. Байгууллагын цахим хуудсанд доорх мэдээллүүд байна уу?

№	Мэдээллийн хүрээ	Шалгах мэдээлэл	Тийм	Үгүй
1	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	Эрхэм зорилго		
2		Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт		
3		Тэргүүлэх чиглэл		
4		Албан хаагчийн ёс зүйн дүрэм		
5		Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр		
6		Байгууллагын хаяг		
7		Байгууллагатай холбоо барих утас		
8		Факсын дугаар		
9		Цахим шуудангийн хаяг		
10		Иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарь		
11		Тухайн цахим хуудаснаас шууд холбогдох боломжтой эсэх		
12		Шуудангийн хаяг		
13		Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт		
14		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж		
15		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам заавар		
16	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	Сул орон тооны зар		
17	Төсөв санхүүгийн ил тод байдал	Байгууллагын тухайн жилийн төсөв		
18		Урьд оны төсвийн гүйцэтгэл		
19		Дараа жилийн төсвийн төсөл		
20		Төсвийн гүйцэтгэлийн биелэлт		
21		Хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан		
22		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт		
23		Төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт		
24		Хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ		
25	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	Тендерийн урилга		
26		Тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл		
27		Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан		
28		ХАА-нд хийсэн аудитын тайлан, дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн		

2. Мэдээллийн НАЙДВАРТАЙ байдал

13. Мэдээллийн эх сурвалж тодорхой байна уу?

№	Мэдээллийн хүрээ	Шалгах мэдээлэл	Тийм	Үгүй
1	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	Эрхэм зорилго		
2		Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт		
3		Тэргүүлэх чиглэл		
4		Албан хаагчийн ёс зүйн дүрэм		
5		Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр		
6		Байгууллагын хаяг		
7		Байгууллагатай холбоо барих утас		
8		Факсын дугаар		
9		Цахим шуудангийн хаяг		
10		Иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарь		
11		Тухайн цахим хуудаснаас шууд холбогдох боломжтой эсэх		
12		Шуудангийн хаяг		
13		Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт		
14		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж		
15		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам заавар		
16	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	Сул орон тооны зар		
17	Төсөв санхүүгийн ил тод байдал	Байгууллагын тухайн жилийн төсөв		
18		Урьд оны төсвийн гүйцэтгэл		
19		Дараа жилийн төсвийн төсөл		
20		Төсвийн гүйцэтгэлийн биелэлт		
21		Хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан		
22		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт		
23		Төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт		
24		Хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ		
25	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	Тендерийн урилга		
26		Тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл		
27		Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан		
28		ХАА-нд хийсэн аудитын тайлан, дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн		

3. Мэдээллийн ЦАГ ҮЕИЙН байдал

14. Тухайн мэдээлэл оруулсан хугацааг тавьсан байна уу?

№	Мэдээллийн хүрээ	Шалгах мэдээлэл	Тийм	Үгүй
1	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	Эрхэм зорилго		
2		Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт		
3		Тэргүүлэх чиглэл		
4		Албан хаагчийн ёс зүйн дүрэм		
5		Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр		
6		Байгууллагын хаяг		
7		Байгууллагатай холбоо барих утас		
8		Факсын дугаар		
9		Цахим шуудангийн хаяг		
10		Иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарь		
11		Тухайн цахим хуудаснаас шууд холбогдох боломжтой эсэх		
12		Шуудангийн хаяг		
13		Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт		
14		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж		
15		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам заавар		
16	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	Сул орон тооны зар		
17	Төсөв санхүүгийн ил тод байдал	Байгууллагын тухайн жилийн төсөв		
18		Урьд оны төсвийн гүйцэтгэл		
19		Дараа жилийн төсвийн төсөл		
20		Төсвийн гүйцэтгэлийн биелэлт		
21		Хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан		
22		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт		
23		Төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт		
24		Хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ		
25	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	Тендерийн урилга		
26		Тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл		
27		Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан		
28		ХАА-нд хийсэн аудитын тайлан, дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн		

15. Тухайн мэдээлэл ашиглагчид зориулж боломжит хугацаанд нийтэлсэн байна уу?

№	Мэдээллийн хүрээ	Шалгах мэдээлэл	Тийм	Үгүй
1	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	Эрхэм зорилго		
2		Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт		
3		Тэргүүлэх чиглэл		
4		Албан хаагчийн ёс зүйн дүрэм		
5		Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр		
6		Байгууллагын хаяг		
7		Байгууллагатай холбоо барих утас		
8		Факсын дугаар		
9		Цахим шуудангийн хаяг		
10		Иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарь		
11		Тухайн цахим хуудаснаас шууд холбогдох боломжтой эсэх		
12		Шуудангийн хаяг		
13		Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт		
14		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж		
15		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам заавар		
16	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	Сул орон тооны зар		
17	Төсөв санхүүгийн ил тод байдал	Байгууллагын тухайн жилийн төсөв		
18		Урьд оны төсвийн гүйцэтгэл		
19		Дараа жилийн төсвийн төсөл		
20		Төсвийн гүйцэтгэлийн биелэлт		
21		Хагас бутэн жилийн санхүүгийн тайлан		
22		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт		
23		Төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт		
24		Хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ		
25	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	Тендерийн урилга		
26		Тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл		
27		Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан		
28		ХАА-нд хийсэн аудитын тайлан, дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн		

16. Тухайн мэдээлэл тогтмол шинэчлэгддэг эсэх?

№	Мэдээллийн хүрээ	Шалгах мэдээлэл	Тийм	Үгүй
1	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	Эрхэм зорилго		
2		Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт		
3		Тэргүүлэх чиглэл		
4		Албан хаагчийн ёс зүйн дүрэм		
5		Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр		
6		Байгууллагын хаяг		
7		Байгууллагатай холбоо барих утас		
8		Факсын дугаар		
9		Цахим шуудангийн хаяг		
10		Иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарь		
11		Тухайн цахим хуудаснаас шууд холбогдох боломжтой эсэх		
12		Шуудангийн хаяг		
13		Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт		
14		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж		
15		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам заавар		
16	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	Сул орон тооны зар		
17	Төсөв санхүүгийн ил тод байдал	Байгууллагын тухайн жилийн төсөв		
18		Урьд оны төсвийн гүйцэтгэл		
19		Дараа жилийн төсвийн төсөл		
20		Төсвийн гүйцэтгэлийн биелэлт		
21		Хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан		
22		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт		
23		Төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт		
24		Хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ		
25	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	Тендерийн баримт бичиг, урилга		
26		Тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл		
27		Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан		
28		ХАА-нд хийсэн аудитын тайлан, дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн		

4. Вебсайтын ХҮРТЭЭМЖТЭЙ байдал

№	Шалгах мэдээлэл	Тийм	Үгүй
17	Асуулт хариултын булан		
18	Хэлэлцүүгийн булан		
19	Холбоотой байгуулагын холбоос линк		
20	Тогтмол асуудаг асуултуудын хариулт (FAQ)		
21	Хэлний сонголт		

5. Вебсайтын АШИГЛАХАД ХЯЛБАР байдал

№	Шалгах мэдээлэл	Тийм	Үгүй
22	Сайтын үсгийн фонт тохиромжтой, харагдахуйц байна уу?		
23	Сайтын Menü ойлгомжтой уу?		
24	Сайтанд өнгөний зохицол байна уу?		
25	Сайтын бүх мэдээлэл нь нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байна уу?		
26	Сайтаас мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай программыг татаж авах боломжтой байна уу?		
27	Дурын browser-ээс тухайн сайт руу орох боломж байна уу?		
28	Сайтанд алдаа гарч байгаа тохиолдолд шийдэх арга замыг зааж өгч байна уу?		
29	Сайтад хайлтын цэс байна уу?		
30	Сайтанд Sitemap байна уу?		
31	Сайтаас хэвлэх боломж байна уу?		
32	Сайтанд файлыг хадгалах боломж байна уу?		
33	Сайтнаас мэдээллийг бусдад илгээх боломж байна уу?		

ХАВСРАЛТ 2. СУДЛААЧДЫН ГАРЫН АВЛАГА

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОДБАЙДАЛ” ВЭБ МОНИТОРИНГ-2011 (Судлаачдын гарын аялгаа)

1. Мониторингийн зорилго

Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах зорилгоор төрийн байгууллагын вэбсайтад мониторинг хийж, “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2009 оны 5 дугаар сарын 14-ны өдрийн 143 дугаар тогтоол (цаашид тогтоол гэх)-ын хэрэгжилтийг үнэлэх, цаашдын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор санал, зөвлөмж боловсруулахад мониторингийн зорилго оршино.

2. Мониторингийн хамрах хүрээ

Монгол улсын яам -11

Монгол улсын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлаг -43

Монгол улсын орон нутгийн захиргаа- 21

Монгол улсын шүүх байгууллага- 15

Улсын Их Хурлын харьяа байгууллагууд -10

Нийт -100 вебсайт

3. Судалгааны анкет бөглөх зааварчилгаа

Судалгааны анкетыг бөглөхдөө дараахь утгуудыг ашиглана.

№	Бөглөх утга	Утга	Тайлбар	Аль нүдэнд бөглөх
1	2	Шалгуур хангасан	Зааварчилгааг дагана уу	Тийм гэсэн нүдэнд
2	1	Шалгуурыг хангаагүй	Зааварчилгааг дагана уу	Үгүй гэсэн нүдэнд
3	888	Тухайн утгад хамааралгүй	Зааварчилгааг дагана уу	Үгүй гэсэн нүдэнд
4	777	Шинжилгээ хийх мэдээлэл байхгүй	Хэрэв 12 дугаар хүснэгтэд 1 буюу шалгуур хангаагүй гэж бөглөсөн бол 13-16 хүснэгтийн холбогдох нүдэнд ашиглана	Үгүй гэсэн нүдэнд

4. Судалгааны асуултуудад хариулах зааварчилгаа

№	Асуулт	Тайлбар
1	Судлаачийн нэр	Судлаач өөрийн нэрийг бүтэн бичих
2	Анкетын дугаар	Судлаач тухайн анкет өөрийх нь бөглөсөн хэд дэх анкет болж байгаа талаар дугаарлах
3	Байгууллагын нэр	Вэбсайтад нь хандаж буй байгууллагын албан ёсны бүтэн нэрийг бичих
4	Вэбсайтуудын хаяг	Хандаж буй байгууллагын албан ёсны вэбсайтуудын хаягийг бичих
5	Судлаач тухайн вэбсайтад хандалтын тэмдэглэгээ	Судлаач вэбсайтад хандсан он, сар, өдөр, цаг, минутыг бичих
		Хэрэв вэбсайтуудын хаягийг бичихэд нэвтрэхгүй байвал www.google.mn сайтад байгууллагын нэрийг бичин хайлт хийж нэвтрэх
		Хэрэв дахин нэвтрэхгүй байвал www.pmis.gov.mn сайтад хандан тухайн байгууллагын холбоос линкээр нэвтрэх
9	Вэбсайтад хандсан үйлчлүүлэгчдийн тоог харах боломж байна уу?	Тухайн байгууллагын вэбсайтаар зочилсон үйлчлүүлэгчдийн тоог харах боломжтой эсэх
10	Вэбсайтад хандсан үйлчлүүлэгчдийн тоо	Хэрэв үйлчлүүлэгчдийн тоог харах боломжтой бол нийт болон жил, сар, өдөрт зорчсон хүний тоог бичих
11	Вебсайтад сэтгэгдэл үлдээх боломжтой байна уу?	Тухайн вэбсайтад нийтлэгдсэн мэдээ мэдээлэлд сэтгэгдэл үлдээх боломж байгаа эсэх

12. Байгууллагын вэбсайтад доорх мэдээллүүд байна уу?

№	Мэдээллийн хүрээ	Шалгах мэдээлэл	Тийм	Үгүй	Тайлбар
1	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	Эрхэм зорилго			Эрхэм зорилго гэх үгээр томъёологдсон утга бүхий мэдээлэл байгаа эсэх
2		Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт			Үйл ажиллагааны стратеги эсвэл зорилго эсвэл зорилт хэмээн томъёологдсон мэдээлэл байгаа эсэх
3		Тэргүүлэх чиглэл			Байгууллагын тэргүүлэх чиглэл хэмээн томъёологдсон мэдээлэл байгаа эсэх
4		Албан хаагчийн ёс зүйн дүрэм			Тухайн байгууллагын эсвэл төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм байгаа эсэх
5		Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр			Вэбсайтаар дамжин болон өөр ямар нэгэн байдлаар тухайн байгууллагатай холбогдоход зориулан тавьсан мэргэжилтний овог нэр байгаа эсэх
6		Байгууллагын хаяг			Байгууллагын хаяг дэлгэрэнгүй зурган хэлбэрээр эсвэл албан ёсны товч хаяг байх
7		Байгууллагатай холбоо барих утас			Байгууллагын аливаа нэгэн газар хэлтэстэй шууд холбогдох утасны дугаар байгаа эсэх
8		Факсын дугаар			Факсын дугаар байх
9		И-мэйл хаяг			Байгууллагатай шууд эсвэл аль нэг албан хаагчтай харилцах и-мэйл хаяг байгаа эсэх
10		Шуудангийн хаяг			Байгууллагын шуудангийн хаяг байгаа эсэх
11		Тухайн цахим хуудаснаас шууд холбогдох боломжтой эсэх			Иргэдийн санал хүсэлт авах эсвэл зөвлөгөө өгөх зорилгоор тухайн байгууллагын албан хаагчтай онлайн чатаар шууд холбогдож болдог эсэх
12		Иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарь			Байгууллагаас иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь эсвэл олон нийттэй харилцах албан хаагчийн иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарь байгаа эсэх
13		Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт			Тухайн байгууллагаас үзүүлдэг үйлчилгээнд иргэдээс шаарддаг материалын жагсаалт байгаа эсэх
14		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж			Байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, бусад эрх үүргийг зохицуулсан Хууль болон УИХ, ЗГ-ын тогтоол 1 ба түүнээс дээш байгаа эсэх
15		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам заавар			Байгууллагын эрхлэх ажлын хүрээнд тухайн байгууллагын сайд, дарга болон холбогдох бусад байгууллагын сайд даргын тушаал шийдвэр 1 ба түүнээс дээш байгаа эсэх
16	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	Сул орон тооны зар			Байгууллагаас зарласан ямар нэгэн сул орон тооны зар /ажлын зар/ 1 ба түүнээс дээш байгаа эсэх
17	Төсөв санхүүгийн ил тод	Байгууллагын тухайн жилийн			Тухайн байгууллагын жилийн батлагдсан төсөв

	байдал	төсөв		
18		Үрьд оны төсвийн гүйцэтгэл		Төсвийн гүйцэтгэл гэх баримт бичиг байгаа эсэх
19		Дараа жилийн төсвийн төсөл		Төсвийн төсөл гэх баримт бичиг байгаа эсэх
20		Төсвийн гүйцэтгэлийн биелэлт		Төсвийн гүйцэтгэлийн биелэлт гэх баримт бичиг байгаа эсэх
21		Хагас бутэн жилийн санхүүгийн тайлан		Хагас болон бутэн жилийн санхүүгийн тайлан гэх бичиг баримт байгаа эсэх
22		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт		Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт эсвэл аудитын дүгнэлт гэх баримт бичиг байгаа эсэх
23		Төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт		Аль нэг оны төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт гэх баримт бичиг байгаа эсэх
24		Хууль тогтоомжид зассан төлбөр хураамжийн хэмжээ		Тухайн байгууллагаас үзүүлдэг үйлчилгээнд оногдох төлбөр, хураамжийн хэмжээ байгаа эсэх
25	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	Тендерийн урилга		Захиалагч болох тухайн төрийн байгууллагаас тендер шалгаруулалт явуулах тухай мэдэгдсэн баримт бичиг 1 ба түүнээс дээш байгаа эсэх
26		Тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл		Тендерт шалгарсан байгууллагын тухай мэдээлэл шалгарсан үндэслэл мен шалгараагүй байгууллагын тухай мэдээлэл яагаад шалгараагүй талаарх тайлбарыг тусгасан мэдээлэл 1 ба түүнээс дээш
27		Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан		Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан гэх баримт бичиг байгаа эсэх
28		ХАА-нд хийсэн аудитын тайлан, дүгнэлт бусад хяналт шалгалтын дүн		ХАА-нд хийсэн аудитын тайлан эсвэл дүгнэлт гэх баримт бичиг байгаа эсэх

13. Мэдээллийн эх сурвалж тодорхой байна уу?

№	Мэдээллийн хүрээ	Шалгах мэдээлэл	Тийм	Үгүй	Тайлбар
1	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	Эрхэм зорилго		888	Тухайн утгад хамааралгүй
2		Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт		888	Тухайн утгад хамааралгүй
3		Тэргүүлэх чиглэл		888	Тухайн утгад хамааралгүй
4		Албан хаагчийн ёс зүйн дүрэм		888	Тухайн утгад хамааралгүй
5		Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр		888	Тухайн утгад хамааралгүй
6		Байгууллагын хаяг		888	Тухайн утгад хамааралгүй
7		Байгууллагатай холбоо барих утас		888	Тухайн утгад хамааралгүй
8		Факсын дугаар		888	Тухайн утгад хамааралгүй
9		Цахим шуудангийн хаяг		888	Тухайн утгад хамааралгүй
10		Иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарь		888	Тухайн утгад хамааралгүй
11		Тухайн цахим хуудаснаас шууд холбогдо боломжтой эсэх		888	Тухайн утгад хамааралгүй
12		Шуудангийн хаяг		888	Тухайн утгад хамааралгүй
13		Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт		888	Тухайн утгад хамааралгүй
14		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж		888	Тухайн утгад хамааралгүй
15		Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам заавар		888	Тухайн утгад хамааралгүй
16	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	Сул орон тооны зар			Сайт дээрх сул орон тооны зартай холбоотой хамгийн сүүлийн нэг мэдээллийг бэлтгэсэн 1. хүний нэр, 2. албан тушаал, 3. хэлтэс, газар, 4. хаяг 5. Утас 6. И-мэйл хаяг 7. байгууллагын нэр 8. холбоос линк зэргийн аль нэг нь байгаа эсэх
17	Төсөв санхүүгийн ил тод байдал	Байгууллагын тухайн жилийн төсөв			Тухайн баримт, мэдээлэл дээр: 1. хүний нэр, 2. албан тушаал, 3. хэлтэс, газар, 4. хаяг 5. Утас 6. И-мэйл хаяг 7. байгууллагын нэр

					8. холбоос линк зэргийн аль нэг байгаа эсэх. Анхааруулахад төсөвтэй холбоотой хэсгүүд тусдаа ворд эсвэл ПДФ хэлбэрээр байж болох тул түүн рүү нь орж харснаар бөглөнө.
18		Урьд оны төсвийн гүйцэтгэл			Дээрхтэй ижил
19		Дараа жилийн төсвийн төсөл			Дээрхтэй ижил
20		Төсвийн гүйцэтгэлийн биелэлт			Дээрхтэй ижил
21		Хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан			Дээрхтэй ижил
22		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт			Дээрхтэй ижил
23		Төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт			Дээрхтэй ижил
24		Хууль тогтоомжид зассан төлбөр хураамжийн хэмжээ			Дээрхтэй ижил
25	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	Тендерийн урилга			Тендерийн талаарх сүүлийн нэг мэдээлэл, баримт бичиг дээр: 1. хүний нэр, 2. албан тушаал, 3. хэлтэс, газар, 4. хаяг 5. Утас 6. И-мэйл хаяг 7. байгууллагын нэр 8. холбоос линк зэргийн аль нэг байгаа эсэх.
26		Тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл			Дээрхтэй ижил
27		Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан			Дээрхтэй ижил Анхааруулахад төсөвтэй холбоотой хэсгүүд тусдаа ворд эсвэл ПДФ хэлбэрээр байж болох тул түүн рүү нь орж харснаар бөглөнө.
